



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2025 • № 72

Б.ЛХАГВАСҮРЭН
ИНФЛЯЦ СҮҮЛИЙН
ГУРВАН САРЫН
ТУРШ СААРЛАА

THE GLOBAL ECONOMY IN THE AGE OF
SUPPLY SHOCKS AND TRADE DISRUPTION
IMPLICATIONS FOR MONETARY POLICY

HIGH-LEVEL INTERNATIONAL CONFERENCE JUNE 15-16
ULAANBAATAR, MONGOLIA



Тайлбар: Монголбанк “Нийлүүлэлтийн шок ба худалдааны саад бэрхшээлийн эрин дэх дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр дагавар” Олон Улсын дээд түвшний хоёр дахь удаагийн хурлыг зохион байгуулав.

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МОНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

БОДЛОГЫН ХҮҮГ ХЭВЭЭР ХАДГАЛАХ, ТЭТГЭВРИЙН ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Дугаар: 2025/03

Огноо: 2025 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2025 оны 6 дугаар сарын 12, 13-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, дотоод, гадаад орчны төлөв, эрсдэлийг харгалzan үзээд:

- Бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах;
- Банкнаас шинээр олгох болон тус шинээр олгосон зээлийн нөхцөлийг нь өөрчлөх тэтгэвэр, тэтгэмжийн орлого барьцаалсан зээлийн хувьд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг бусад хэрэглээний зээлийн адилaaар 50 хувиар тогтоохоор шийдвэрлэлээ.

Жилийн инфляц алгуур саарч, 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувь, Улаанбаатар хотод 9.4 хувьтай гарлаа. Инфляц ийнхүү саarahад мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болон импортын барааны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлөв. Инфляц хүлээлтээс эрт саarah хандлага ажиглагдаж эхэлсэн хэдий ч зарим төрийн зохицуулалттай бараа болон үйлчилгээний үнийн өсөлтийн нөлөөгөөр инфляц энэ онд Төв банкны зорилтоос өндөр байх хүлээлт хэвээр байна. Инфляцын цаашдын төлөв Засгийн газраас хэрэгжүүлэх төслүүд, түүний санхүүжилт, экспортын орлого болон валютын ханшийн төлөв, цаг агаар болон нийлүүлэлтээс шалтгаалсан хүнсний үнийн өөрчлөлтөөс хамаарна.

Эдийн засгийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 2.4 хувьд хүрч хүлээлтээс бага гарлаа. Голлох эрдэс бүтээгдэхүүний олборлолт буурсан, тээврийн салбарын орлого хурдтай саарсан, татвар, худалдааны салбарын үйлдвэрлэл агшсан зэрэг нь өсөлт саarahад нөлөөллөө. Энэ онд хөдөө аж ахуйн салбар зудын хүндрэлээс сэргэх, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдэх, шинэ төслүүдийн бүтээн байгуулалт эхлэх зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дэмжих хүлээлтэй байна.

Гадаад орчны хувьд геополитикийн нөхцөл байдал, улс орнуудын худалдааны бодлоготой холбоотойгоор тодорхой бус байдал нэмэгдэж, гадаад эрэлт, түүхий эдийн үнэд сөргөөр нөлөөлж байна. Харин алт, зэсийн үнэ харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь манай улсын худалдааны нөхцөлд зэрэг нөлөөтэй байна.

Тэтгэврийн орлого барьцаалсан зээл сүүлийн жилүүдэд хурдтай нэмэгдэж, тэтгэврийн зээлдэгчдийн хувьд өр төлбөрийн дарамт, санхүүгийн ачаалал өндөр болсон бөгөөд цаашид ч хүндрэх эрсдэлтэй байна. Иймд тэтгэврийн зээлийг зохистой түвшинд нь зохицуулах шаардлага байна.

Дээрх бодлогын шийдвэр нь инфляцын хүлээлтийг тогтвортжуулах замаар инфляцыг 2026 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтвортжуулах, 2027 оноос +/-2 нэгж хувийн интервалд 5 хувьд хүргэх Төв банкны зорилтой нийцтэй бөгөөд дунд хугацаанд макро эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжихэд чиглэж байна.

Цаашид гадаад, дотоод эдийн засгийн орчинд гарах өөрчлөлт болон инфляц, эдийн засгийн төлөв хэрхэн өөрчлөгдхөөс хамаарч Мөнгөний бодлогын хороо бодлогын дараагийн алхмыг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МОНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО

ЭНЭ ДУГААРТ



04

ИНДЭР

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ХОРООНЫ
2 ДУГААР УЛИРЛЫН
ШИЙДВЭРИЙГ
ТАНИЛЦУУЛАХ
ХЭВЛЭЛИЙН ХУРАЛД
МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ЛХАГВАСҮРЭНГИЙН
ХЭЛСЭН ҮГ



06

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛБАНКНЫ
УДИРДЛАГА ОЛОН
УЛСЫН ВАЛЮТЫН
САН, ДЭЛХИЙН
БАНКНЫ ХАВРЫН
УУЛЗАЛТАД
ОРОЛЦЛОО



09

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

“НИЙЛҮҮЛЭЛТИЙН
СААТАЛ БОЛОН
ХУДАЛДААНЫ
ШОКТОЙ ЭРИН ДЭХ
ДЭЛХИЙН ЭДИЙН
ЗАСАГ: МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ҮР
ДАГАВАР” ОЛОН
УЛСЫН ӨНДӨР
ТҮВШНИЙ II ХУРАЛ
МОНГОЛ УЛСАД
АМЖИЛТТАЙ ЗОХИОН
БАЙГУУЛАГДЛАА



31

ЗОЧИН


ТҮВШИНТӨГС:
НИЙЛҮҮЛЭЛТИЙН
ШОК, ТАРИФЫН
НӨЛӨӨ ГЛОБАЛ
ЭДИЙН ЗАСАГТ
ТУЛГАРААД БАЙНА



41

ОЛОН УЛСЫН ТОЙМ

ГАДААД ЭДИЙН
ЗАСАГТ ГАРЧ БУЙ
ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ



47

СУДАЛГАА

“ТӨСВИЙН
ЗАРДЛЫН МӨЧЛӨГ,
ТҮҮНИЙ ҮР АШИГ”



11

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

“БИД ЗУУН ЖИЛД
БАЙГААГҮЙ ӨНДӨР
ТАРИФЫГ УРТ
ХУГАЦААНД ТУУЛЖ
МАГАДГҮЙ.”

35

НИЙТЛЭЛ

КОВИД-19 ЦАР
ТАХЛЫН ҮЕИЙН
ДНБ-ИЙ АЛДАГДАЛ
БОЛОН БОДЛОГЫН
ХАРИУ АРГА
ХЭМЖЭЭ



МӨНГӨНИЙ ТАНИЛЦУУЛ ДАЛОГЫН ХЭВЛЭЛИЙН ХУРЛЫН ҮЕЭР



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН ШИЙДВЭРИЙГ ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН ХУРЛЫН ҮЕЭР МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХЭЛСЭН ҮГ

(2025.06.13)

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе!

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 6 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд хуралдаж, бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах, тэтгэврийн зээлийн зохицуулалтад өөрчлөлт оруулах шийдвэрийг тус тус гаргалаа.

Эдгээр бодлогын шийдвэрийг гаргахад дараах эдийн засгийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан үзлээ. Үүнд,

- АНУ-аас хэрэгжүүлж буй тарифын бодлогын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн өсөлт энэ онд удаашрах төлөвтэй байгааг олон улсын шинжээчид анхааруулж байна. Үүнээс шалтгаалан эрдэс бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл нэмэгдэж байна.
- Худалдааны дайны эрсдэлтэй зэрэгцэн БНХАУ-д үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж байгаа нь гангийн эрэлт,

нүүрс, төмрийн хүдрийн үнэд сөргөөр нөлөөлж байна.

Инфляц сүүлийн гурван сарын турш саарч, 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувь, Улаанбаатар хотод 9.4 хувьтай гарлаа.

- Инфляц ийнхүү саарахад мах, гурил зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлт хүлээлтээс бага, мөн импортын барааны үнэ хүлээлтээс багаар өссөн нь голлоо нөлөөг үзүүллээ.
- Түүнчлэн, ҮСХ-оос тооцдог хэрэглээний үнийн индексийн сагс шинэ суурьт шилжсэн нь инфляцын тооцооллыг өөрчилж, өмнөхөөс бууруулаа.
- Засгийн газрын шийдвэрийн дагуу төрөөс үзүүлж буй үйлчилгээний төлбөрийг энэ онд нэмэхгүй байх шийдвэр гарсан, дотоодын хүнс, импортын бараа, бүтээгдэхүүний үнэ

хүлээлтээс бага гарсан зэргээс шалтгаалан энэ оны инфляцын төсөөллийг өмнөхөөс буурууллаа.

- Ийнхүү инфляц ирэх улирлуудад 9-10 хувийн орчимд хэлбэлзэж, оны сүүлээс алгуур буурсаар 2026 оны 1 дүгээр улиралд Төв банкны зорилtot интервалд орж буурахаар байна.
- Гэхдээ дэлхийн зах зээлд нүүрсний үнэ буурч, гадаад орчны эмзэг байдал өндөр байгаа энэ үед томоохон төслүүдийг дотоодоос санхүүжүүлэх шаардлага үүсвэл төгрөгийн ханшид ирэх дарамт нэмэгдэж, инфляцыг эрчимжүүлж болзошгүй анхаарах нь зүйтэй.

Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьтай буюу хүлээлтээс бага гарлаа.

- Үүнд, зэс, алт, нүүрсний олборлолт багассан, нүүрсний үнэ буурсантай холбоотойгоор тээврийн салбарын орлого агшиж, худалдааны салбарын идэвхжил буурсан зэрэг нь голлон нөлөөлөв.
- Өсөлтийн хурд ийнхүү саарсан ч энэ оны эдийн засгийн өсөлт б орчим хувьтай гарах хүлээлттэй байна.
- Хэдийгээр нүүрсний орлого буурч байгаа боловч экспортын биет хэмжээ өмнөх оны түвшинд байх, зэсийн баяжмалын олборлолт эрчимжих нь уул уурхайн салбарыг дэмжих, хаврын саруудад мал төллөлт, төл малын бойжилт сайн байснаар хөдөө аж ахуйн салбар зудын хүндрэлээс сэргэх зэрэг нь өсөлтийг голлон тэтгэхээр байна.
- Цаашлаад бүтээн байгуулалтын төслүүдийн хэрэгжилтийн явц, гадаад, дотоод эрэлт, түүхий эдийн үнэ зэрэг нь өсөлтийн төлөвт нөлөөлөхөөр байна.

Төлбөрийн тэнцлийн цаашдын төлөвт нүүрсний үнийн бууралт томоохон эрсдэлийг дагуулж байна. Том гүрнүүдийн худалдааны сөргөлдөөн хэрхэн үргэлжилж, БНХАУ-ын эдийн засаг болон эрдэс бүтээгдэхүүний үнийн төлөв хэрхэн өөрчлөгдхөөс гадаад эрэлт ихээхэн хамаарна.

- Гадаад худалдааны нөхцөл муудаж болзошгүй байгаа энэ үе нь Засгийн газраас хэрэгжүүлэх томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эхлэх хугацаатай давхцаж байна.
- Иймд эдгээр төслүүдийг хэдий хугацаанд хэрхэн санхүүжүүлэх нь төлбөрийн тэнцэл, гадаад валютын албан нөөцийн цаашдын төлөвт чухал нөлөөтэй.

Тэтгэврийн орлого барьцаалсан зээл сүүлийн жилүүдэд хурдтай нэмэгдэж, тэтгэврийн зээлдэгчдийн хувьд өр төлбөрийн дарамт, санхүүгийн ачаалал өндөр байна. Үүнийг харгалзан Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2025 оны 3 дугаар сарын ээлжит хурлаар тэтгэврийн зээлд зохицуулалт хийх шийдвэрийг гаргасан хэдий ч зарим зээлдэгчдийн хувьд шилжилтийн үеийн хүндрэл үүсэж, бодлогын арга хэмжээнд тохируулга хийх шаардлага үүсэд байна.

Ийнхүү гадаад, дотоод орчны нөхцөл байдал, инфляцын цаашдын төлөвийг харгалзан Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэрийг гаргав. Түүнчлэн, тэтгэврийн зээлийн үлдэгдэлтэй, зээлийн өндөр төлбөртэй зээлдэгчдэд үүсээд буй хүндрэлийг шийдвэрлэх хүрээнд зохицуулалтын арга хэмжээг авахаар шийдвэрлэлээ. Тэтгэврийн зээл нь мөн чанарын хувьд цалин барьцаалсан хэрэглээний зээлтэй адил тул нэгдсэн нэг стандартыг мөрдүүлэх алгуур шилжилтийг хэрэгжүүлж байна. Хэрэв энэ зохицуулалтыг тодорхой хугацаанд хэрэгжүүлэхгүй хойшлуулвал ахмад настнуудын санхүүгийн нөхцөл байдал улам хүндрэх бөгөөд цаашид шийдвэрлэхэд илүү бэрхшээлтэй болохыг тооцоо, судалгааны үр дүн харуулж байна.

Монголбанкны бодлогын шийдвэр нь инфляцыг дунд хугацаанд зорилтолт түвшинд тогтвржуулах, эдийн засаг, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилттой нийтэй болно. Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын төлөв, нийлүүлэлтийн хүчин зүйлс, олон улсад бийиж буй өөрчлөлтүүдтэй уялдуулан бодлогын дараагийн алхмыг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

● МОНГОЛБАНК ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН, ДЭЛХИЙН БАНКНЫ ХАВРЫН УУЛЗАЛТАД ОРОЛЦЛОО

2025-05-02



**SPRING
MEETINGS**
2025 | WASHINGTON DC
WORLD BANK GROUP
INTERNATIONAL MONETARY FUND

Дэлхийн Банк болон Олон Улсын Валютын Сангийн 2025 оны хаврын чуулга уулзалт дээрэвдүгээр сарын 21–26-нд АНУ-ын Вашингтон хотноо болж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо. Чуулганаар АНУ-ын тарифын бодлогоос улбаалсан дэлхийн худалдааны нөхцөл байдал, өрийн асуудал, тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөө, институцийн шинэчлэлийн талаар олон улсын санхүүгийн салбарын тэргүүлэгид хэлэлцэв. Энэ үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн Дэлхийн Банкны гишүүн байгууллага болох Олон Улсын санхүүгийн корпорациын Ази, Номхон далай хариуссан Дэд ерөнхийлөгч Рикардо Пулийтэй уулзаж, Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, төлөвийн талаар ярилцав.

● МОНГОЛБАНК "УУР АМЬСГАЛЫН СЦЕНАРИ ШИНЖИЛГЭЭ"-НИЙ АНХНЫ ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛЛАА

2025-05-07



Монголбанк НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (ESCAP)-той хамtran, NDC Partnership-ийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Төв банкийг ногоон болгоход бэлэн байдлын дэмжлэг үзүүлэх" төслийн хүрээнд "Уур амьсгалын сценари шинжилгээ"-г гүйцэтгэв. Энэхүү шинжилгээгээр ган, зуд, үер ус зэрэг байгалийн гамшгаас үүдэх хоёр төрлийн биет эрсдэл, мөн ногоон шилжилтээс үүсэх гурван өөр хувилбараар шилжилтийн эрсдэлийг үнэлж тооцжээ. Уур амьсгалын эрсдэл нэмэгдэж буй энэ үед Монгол Улсын санхүүгийн салбарыг үндэсний уур амьсгалын зорилт, олон улсын тогтвортой хөгжлийн стандарттай уялдуулах чухал суурийг тавьж буйгаараа энэхүү шинжилгээ нь өндөр ач холбогдолтой юм.

● БАНКНЫ САЛБАРЫНХАН ОЛОН УЛСЫН ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭНД МОД ТАРИВ

2025-05-09



Бүх нийтийн мод тарих үндэсний өдрийг тохиолдуулан Монголбанк, Монгол Улсын Хөгжлийн банк, арилжааны банкууд, Монголын банкны холбоо, "Тэрбум мод" сан Гачууртготсон дахь Олон Улсын "Эко цэцэрлэг"-т хүрээлэнд 300 навчит мод тарилаа. "Тэрбум мод үндэсний хөтөлбөр"-ийг дэмжих, Монголбанкны санаачлагаар банкнуудтай хамtran "Тэрбум мод сан"-г байгуулж, 2030 он хүртэл улсын хэмжээнд 50 сая мод тарьж, Улаанбаатар хот болон 21 аймагт банкны нэрэмжит төгөл байгуулахаар зорьжээ. Судлаачдын дүгнэснээр сүүлийн 80 жилд Монгол Улсын жилийн дундаж температур цельсиийн 2.2 градусаар нэмэгдэж, дулаарал дэлхийн дунджаас хоёр дахин өндөр байна. Мөн нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь буюу 120 сая га талбай цөлжилтөд өртөж, бэлчээрийн 57 хувь нь доройтсон байна. Иймд оролцогод бүх нийтээрээ мод тарихыг уриаллаа.

○ АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЖИЛИЙН УУЛЗАЛТААР 4 ЧИГЛЭЛД АНХААРЛАА ХАНДУУЛАВ

2025-05-12



Азийн хөгжлийн банкны Ерөнхийлөгч нарын зөвлөлийн 58 дахь удаагийн жилийн уулзалт Италийн Милан хотноо тавдугаар сарын 3-7-нд болж, Монголбанкны төлөөлөл оролцлоо. Уулзалтад улс орнуудын Засгийн газар, банк санхүү, хувийн хэвшил, иргэний нийгэм, академийн төлөөлөл бүхий 5000 гаруй зочин оролцож, Ази, Номхон далайн бус нутагт өөрчлөлт хийхэд шаардлагатай дөрвөн гол чиглэлийн талаар санал солилцлоо. Үнд, бус нутгийн хүнсний тогтолцооны эмзэг байдлыг шийдвэрлэх зорилгоор Азийн хөгжлийн банк 2030 он хүртэл нийт 40 тэрбум ам.долларыг хүнсний тогтолцооны шилжилтийг дэмжихэд зориулахаар байна. Түүнчлэн, боловсрол, санхүү, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дижитал технологид хөрөнгө оруулалт хийхээс гадна эрчим хүчиний системийг шинэчлэх, харилцан холболт хийх төслүүдэд хөрөнгө оруулахаар болсныг мэдэгдэв. Мөн дэд бүтцийг бэхжүүлэх, экосистемийг сэргээх, хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд өртсөн эмзэг бүлгийн иргэдийг дасан зохицоод нь туслах замаар тэсвэртэй байдлыг бий болгох хөрөнгө оруулалтыг гүнзгийрүүлнэ гэдгээ мэдэгдэв.

○ ХАРААНЫ БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ХАМГААЛАЛТЫН ЭЛЕМЕНТИЙГ ТАНИЛЦУУЛАВ

2025-05-16



Үндэсний мөнгөн тэмдэгт “төгрөг”-ийг анх гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан Монголбанкны Мөнгөн тэмдэгтийн газраас Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоотой хамтран “Мөнгөн тэмдэгтийн хамгаалалтын элемент таних” сэдэвт сургалтыг зохион байгуулав. Сургалтаар 2019 онд шинэчлэгдсэн мөнгөн тэмдэгт дэх харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан хамгаалалтын элементүүдийг танилцуулж, практик дадлага хийлгэв. Энэ үеэр оролцогчдоос төлбөр тооцоо хийх үед тулгардаг бэрхшээлийн хүрээнд мөнгөн тэмдэгтийг дэвсгэртээр нь ялан таних арга, хамгаалалтын элементүүдийг илүү сайжруулахад анхаарч, бодлогын саналдаа тусгахыг хүсэв. Мөн энэ чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан санал солилцлоо.

○ ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЖИЛИЙН УУЛЗАЛТАД МОНГОЛБАНКНЫ ТӨЛӨӨЛӨЛ ОРОЛЦОВ

2025-05-19



Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны 34 дэх удаагийн жилийн уулзалт тавдугаар сарын 13-наас 15-ны өдрүүдэд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Лондон хотноо “Хэтийн хүрээг тэлж, бат бэх чадварыг бэхжүүлэх нь” сэдвийн дор боллоо. Уулзалтад Монголбанк, Сангиин яам болон хувийн хэвшлийн төлөөлөл оролцов. Энэ үеэр Монголбанкны төлөөлөл ЕСБХБ-ны Санхүүгийн байгууллагуудыг хариуцсан газрын захирал Жорж Орлов, Төв Азийн бус нутгийг хариуцсан захирал Хүсэйн Өзхан болон Захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлдөг тойргийн захирал Рене ван Хэлл нартай албан уулзалт зохион байгуулж, институц хоорондын хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ. Мөн жилийн уулзалтын үеэр ХААН банк ногоон бизнес болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор 145 сая ам.долларын дун бүхий урт хугацааны санхүүжилтийн хэлцэл байгуулсан нь ЕСБХБ-наас Монголын банк, санхүүгийн байгууллагад олгож буй хамгийн өндөр дүнтэй санхүүжилт боллоо.

● МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

2025-05-23



Монголбанкнаас эдийн засаг, санхүүгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын онолын мэдлэг, судалгааны арга зүйг гүнзгийрүүлж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудад эдийн засгийн дүн шинжилгээ гаргаж, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог дэмжих зорилгоор эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааныг жил бүр зохион байгуулдаг. Энэ жилийн эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд 29 бүтээл ирснээс сүүлийн шатанд 10 бүтээлийг шалгаруулж, 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Монголбанкны баг шилдэг бүтээлийн эздийг тодрууллаа. Энэ удаагийн эрдэм шинжилгээний бүтээлийн уралдаанд оролцогчдын хувьд машин сургалтын аргаар олон хүчин зүйлсийн нөлөөг тооцож ирүүлсэн нь онцлог байлаа.

● "ТӨГРӨГ-100" ОЙГ ТОХИОЛДУУЛАН СУРАГЧДЫН ДУНД ЗОХИОН БАЙГУУЛСАН УРАЛДААНУУДЫН ШИЛДГҮҮДИЙГ ШАЛГАРУУЛЛАА

2025-06-02



Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт "Төгрөг"-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ой 2025 онд тохиож байна. Тэмдэглэлт ойг тохиолдуулан хүүхэд, өсвөр үеийнхэнд төгрөгийн ач холбогдлыг таниулан сурталчлах зорилгоор 6-12 дугаар ангийн сурагчдын дунд эсээ бичлэг, 1-5 дугаар ангийн сурагчдын дунд гар зургийн уралдааныг зохион байгуулав. Тэмцээн тус бүрийг мэргэжлийн хүмүүсийн дэмжлэгтэйгээр гурван үе шаттай шүүж, утга агуулгыг бүрэн илэрхийлсэн байдлыг харгалзан шилдгүүдийг тодруулав. Уралдааны эсээ бичлэгт 300, гар зурагт 90 орчим сурагч бүтээлээ ирүүлсний дийлэнх нь хөдөө орон нутгаас оролцгосод байв. Амжилттай оролцож тэргүүн байруудад шалгарсан сурагчдыг б 2 дугаар сарын 2 -ны өдөр тохиодог "Банкны ажилтны өдөр"-өөр шагнаж урамшуулав.

● "ТУСГААР ТОГТНОЛЫН БЭЛГЭДЭЛ ТӨГРӨГ-100" СЭДЭВТ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН МУЗЕЙГ НЭЭВ

2025-06-04



Орчин цагийн үндэсний мөнгөн тэмдэгт "ТӨГРӨГ"-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан Мөнгөн тэмдэгтийн түүхийн музей нээлээ. Уг музейн танхимд Монгол Улсын төлбөрийн хэрэгсэлтэй холбоотой 1925-2025 он хүртэлх түүхэн баримт бичиг, тухайн он жилүүдэд ашиглагдаж байсан багаж хэрэгсэл, эд зүйлс, шинээр үйлдвэрлэн гаргасан гүйлгээний болон дурсгалын мөнгөн дэвсгэрт, тэдгээрийн загварууд болон үндэсний мөнгөн тэмдэгтийн шинэ дэвшилтэг технологи бүхий хамгаалалтын элементүүдийн тухай танилцуулжээ.

● МОНГОЛБАНКНЫ ТӨЛӨӨЛӨЛ БРИТАНИЙН ПАРЛАМЕНТ ДАХЬ ОЛОН УЛСЫН ПАРЛАМЕНТТАЙ ХАРИЛЦАХ БҮЛГИЙН ГИШҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА

2025-06-25



Британийн парламент дахь Олон улсын парламентын холбоотой харилцах бүлгийн дарга Фабиан Хамильтон тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад айлчлах үеэрээ Монголбанкны төлөөлөлтэй албан уулзалт хийв.

Уулзалтаар Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулж, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс – Монгол Улсын хамтын ажиллагааны хүрээнд худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт, банк, санхүүгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийн талаар харилцан санал солилцлоо.



“НИЙЛҮҮЛЭЛТИЙН СААТАЛ БОЛОН ХУДАЛДААНЫ ШОКТОЙ ЭРИН ДЭХ ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ: МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮР ДАГАВАР” ОЛОН УЛСЫН ӨНДӨР ТҮВШНИЙ II ХУРАЛ МОНГОЛ УЛСАД АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Монголбанк, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хороо (*Reinventing Bretton Woods Committee*) хамтран “Нийлүүлэлтийн saatал болон худалдааны шоктой үе дэх дэлхийн эдийн засаг: Мөнгөний бодлогын үр нөлөө” сэдэвт Олон Улсын хурлыг 2025 оны 6 дугаар сарын 19-нөөс 21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав. Хурлыг нээж, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн хэлсэн угэндээ “Нийлүүлэлтийн гаралтай шокууд нь эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж, бодлого боловсруулагчдад сорилт болж байна. Энэ үед Төв банкнууд мөнгөний бодлогын үр дүнтэй байдлыг дээшлүүлэхийн тулд уламжлалт үүрэг оролцоогоо эргэн харах, тоон болон чанарын мэдээллийг сайжруулах, тооцоолол, дүн шинжилгээний арга техникийг боловсронгуй болгох, мөнгө-сангиин бодлогын уялдааг бэхжүүлж ажиллах шаардлагатай тухай, мөн олон улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх нь бус нутгийн болон дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал юм” хэмээн онцоллоо.

Дэлхийн эдийн засагт цар тахал, уур амьсгалын өөрчлөлт, амьжиргааны өргтийн өсөлт, geopolitikiyin хурцадмал байдал зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалсан хундрэлүүд сүүлийн жилүүдэд зэрэгцэн тохиож, шинэ сорилтууд тулгарсаар байна. Энэ нөхцөл байдал нь мөнгөний болон төсвийн бодлогын чиг баримжаа, харилцан уялдааг дахин эргэж харах, тогтвортой байдлыг хангах шинэ гарц, шийдлийг эрэлхийлэх шаардлагыг үүсгэж байгаа билээ.

Дэлхий нийтэд тулгараад буй энэхүү нийтлэг сорилтуудын талаар өндөр түвшний хэлэлцүүлгийг өрнүүлэх гол талбар болж буй энэ удаагийн хурлаар дараах сэдвүүдийг онцоллоо. Үүнд, дэлхий нийтийг



хамарсан шокийн үе дэх эдийн засгийн нөхцөл байдал, нийлүүлэлтийн шокод үзүүлэх мөнгөний бодлогын арга хэмжээ, Төв банкны оролцоонд гарч буй өөрчлөлтүүд, нийлүүлэлтийн шокод үзүүлэх төсвийн бодлогын арга хэмжээ, хиймэл оюун ухаан, дижиталчлал болон ногоон шилжилтийн макро эдийн засаг дахь үр дагавар, дэлхийн эдийн засгийн хуваагдлын үед хэрэгжүүлэх эдийн засаг, санхүүгийн зохицуулалтын бодлого, арга замууд сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүллээ.

Монголбанк, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хорооны хамтран зохион байгуулж буй олон улсын өндөр түвшний энэхүү хэлэлцүүлэгт 15 орны 20 гаруй зочин төлөөлөгч оролцов. Тэдгээрээс ОУВС-ийн Төсвийн бодлого хариуцсан зөвлөх Митали Дас, Бреттон Вүүдсийн дахин зохион бүтээх хорооны гүйцэтгэх захирал Марк Узан, Солонгосын Хөгжлийн институтын ерөнхийлөгч Дон Чул Чо, Чехийн Төв банкны Ерөнхийлөгч асан Мирослав Сингер, ОУВС-ийн Монгол дахь Суурин төлөөлөгч Тигран Погосиан, АХБ-ны Бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцийн хэлтсийн захирал Жон Ву Канг нар хурлын удирдагч, илтгэгчээр оролцсон бөгөөд нийт зочдын хувьд олон улсын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагууд, судалгаа, хөгжлийн институтын эрдэмтэн, судлаач нар байв. Монгол Улсын талаас холбогдох яамд, арилжааны банкны удирдлагууд, дотоодын зохицуулагч байгууллагууд, судлаачдын төлөөлөл гэсэн өргөн хүрээг хамрав.

Энэхүү өндөр түвшний хурал нь "Монгол Улсад орчин цагийн банкны тогтолцоо үүсэж бэхжэсний 100 жилийн ой"-г тохиолдуулан 2024 онд зохион байгуулсан Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын амжилтад тулгуурлан, дэлхийн бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, эрдэмтэн судлаачид, санхүүгийн тэргүүлэх мэргэжилтнүүдийг нэг дор урин цуглуулж, дэлхийн эдийн засагт тулгарсаар буй сорилтууд, тэдгээрийг даван туулах бодлогын зохистой арга хэмжээ, тэр дундаа мөнгөний бодлогын хүрээнд гарч буй сорилтын талаар хэлэлцүүлэх үндсэн зорилготой юм.

Бид товхимлынхоо энэ удаагийн дугаарт тус хурлын талаар дэлгэрэнгүй мэдээлэхээр хэлэлцүүлэг тус бүрээр нь тоймлон уншигч танд танилцуулж байна.

НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОК БА ХУДАЛДААНЫ СААД БЭРХШЭЭЛИЙН ЭРИН ДЭХ ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ: МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮР ДАГАВАР ХУРАЛ



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСУРЭНГИЙН ТАНИЛЦУУЛСАН ҮНДСЭН ИЛТГЭЛ

**Эрхэм хүндэт зочид, хамт
олон, анд нөхөд,
Хүндэт ноёд, хатагтай нар,
Та бүхэнд өглөөний мэнд
хүргэе!**

Та бүхэн Монгол Улсад саатан морилж буйд миний бие баяртай байна. Монголбанкны нэрийн өмнөөс та бүхэнд халуун мэндчилгээ дэвшүүлье!

Дэлхийн өнцөг булан бүрээс бодлого боловсруулагчид, эдийн засагчид болон институциудын лидер, удирдлагууд энэхүү дээд хэмжээний хуралд оролцохоор хуран цугласан байгаа нь нэр төрийн хэрэг билээ. Та бүхэн өнөөдөр энд хүрэлцэн ирсэн нь дэлхийн эдийн засаг шинэ эрин үед шилжиж байгааг хүлээн зөвшөөрч байгаагийн илрэл юм. Энэхүү шинэ эрин нь өсөн нэмэгдэж буй тодорхойгүй байдал, геополитикийн хүчиний тэнцвэрийн өөрчлөлт, худалдааны тогтсон хэв маягийн өөрчлөлт, давтамж нь ихсээд

буй нийлүүлэлтийн шок зэрэг хүчин зүйлсээр тодорхойлогдож байна.

Тус хурал нь эдгээр хүчин зүйлс дэлхийн эдийн засгийн тогтвортгүй байдалд илүү өртөмтгийн орнуудын мөнгөний болон төсвийн бодлогод хэрхэн нөлөөлж буйг илүү сайн ойлгох боломжийг бидэнд олгож байгаа учраас цагаа олсон үйл явдал юм. Бус нутаг дамнасан, бодит туршлага солилцох хэлэлцүүлгүүдийн үр дунд бид дэлхий улам бүр хуваагдмал болж буй энэ үед эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эдийн засгийн хүндрэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх арга замуудын талаар ач холбогдол бүхий санал, санаачилгыг хамтдаа бий болгоно гэдэгт итгэж байна. Бидний өмнө тулгарч буй сорилтууд аль нэг байгууллага, эсвэл бодлогын хүрээнд

дангаараа шийдэгдэхээргүй өргөн хүрээтэй юм. Ийм нөхцөл байдалд төв банкнууд хооронд болон бодлого боловсруулагчдын хүрээлэлд туршлага, мэдлэгийг нээлттэй бөгөөд тасралтгүй солилцох нь туйлын чухал билээ. Бид харилцан биеэсээ суралцаж, хамтран ажилласнаар энэхүү төвөгтэй, тодорхойгүй байдалд тохирсон хэрэгслийг бий болгох боломж бүрдэнэ.

Ийнхүү өнөөдрийн нээлтийн илтгэлийг дараах 4 чиглэлээр бэлтгэлээ. Үүнд:

- Дэлхийн эдийн засгийн орчин ба шок
- Төв банкнуудын өмнө тулгарч буй сорилтууд
- Монгол Улсад үзүүлэх нөлөө: Байгалийн нөөцөөр баялаг, жижиг нээлттэй эдийн засаг
- Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлууд

II ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН БА ШОК

Дэлхийн эдийн засгийн орчин гүнзгий өөрчлөлтөд орж байна. Өмнө нь түр зуурын тасалдал гэж тооцогдог байсан нийлүүлэлтийн шокууд одоо илүү олон давтамжтай, удаан үргэлжлэх шинжтэй бөгөөд нарийн төвөгтэй болж байна. Геополитикийн хурцадмал байдал, уур амьсгалын өөрчлөлтэй холбоотой үзэгдлүүд, худалдааны хуваагдал, цар тахал, технологийн шилжилт зэрэг хүчин зүйлс хоорондоо харилцан үйлчилж, дэлхийн үйлдвэрлэл, тээвэр ложистик болон үнийн түвшинд байнгын дарамт учруулж байна.

Үүний зэрэгцээ дэлхийн худалдааны бүтэц өөрчлөгднөн хөгжиж байна. Өртгийн сүлжээ шинэчлэгдэж, хүндрэлд тэсвэртэй байдал, аюулгүй байдал болон бүс нутгийн төвлөрөл улам бүр ач холбогдолтой болж байна. Үр дүнд нь төв банкнууд болон бодлого боловсруулагчид өмнөхөөс тэс өөр орчинд ажиллах боллоо. Энэ орчинд нийлүүлэлтийн талын хүчин зүйлүүд макро эдийн засаг, санхүүгийн орчныг бий болгоход улам чухал үүрэг гүйцэтгэж байна.

Эдгээр шок нь өргөн цар хүрээтэй, гүнзгий үр дагавартай. Макро эдийн засгийн түвшинд

нийлүүлэлтийн доголдол нь инфляцыг тогтвортгүй болгож, өсөлтийн төлөвийг тодорхойлоход хүндрэлтэй байдалд оруулж байна.

Ялангуяа Монгол шиг нээлттэй бөгөөд байгалийн нөөцөөс хамааралтай эдийн засгийн хувьд түүхий эдийн үнийн огцом өөрчлөлт, худалдааны урсгал, хөрөнгийн хөдөлгөөн зэрэг нь санхүүгийн тогтвортгүй байдал үүсгэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа билээ. Үүн дээр валютын ханшийн хэлбэлзэл, дэлхийн санхүүгийн нөхцөл байдалд гарч буй өөрчлөлтүүд, улс орнуудын бодлогын зөрүүтэй хариу арга хэмжээ зэрэг нь нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлж байна.

Ийм нөхцөл байдалд төв банкнууд үнийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд илүү нарийн шинжилгээний арга хэрэгсэл, илүү уян хатан бодлогын хамрах хүрээ, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагаа урьд урьдынхаас илүү тулгарч байна.

Одоо дэлхийн эдийн засгийн орчин нь төв банкнуудын өмнө ямар сорилтуудыг бий болгож байгааг авч үзье.

III ТӨВ БАНКНУУДЫН ӨМНӨ ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТУУД

Эрхэм хүндэт зочид, эрхэм нөхөд өө,

Би өмнө нь дурдсанчлан, бид бүгд хурдтай өөрчлөгджө буй, урьдчилан таамаглах аргагүй дэлхийд ажиллаж, амьдарч байна. Геополитик, худалдааны саатал, технологийн шилжилт, эрчим хүчний шилжилт, уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүчин зүйлсээр өдөөгдсөн нийлүүлэлтийн талын шокууд нь дэлхийн эдийн засгийг шинэ чиглэлд хөтөлж, уламжлалт бодлогын хамрах хүрээнд сорилт болж байна.

Ийм нөхцөл байдал нь төв банкны үндсэн зорилт, ашиглаж буй арга хэрэгсэл, олон нийттэй харилцах арга барил зэргийг нягтлах шаардлагатай болгож байна. Энэ хүрээнд би дараах гурван чиглэлд бодлоо хуваалцахыг хүсэж байна:
үндсэн зорилт, бодлогын хамрах хүрээний шинэчлэл, мөнгө ба төсвийн бодлогын уялдаа холбоо.

а) Үндсэн зорилтоо эргэж харах

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд төв банкнуудын мандат буюу үүрэг хариуцлага шинэ нөхцөл байдал, шинээр гарч ирж буй эрсдэлүүдэд нийцэн ихээхэн өөрчлөгдсөн. Харин өнөөдөр бидний өмнө тулгарч буй гол

асуудал бол төв банкны мандат цаашид хэрхэн өөрчлөгдөх ёстой вэ, мөн энэ шинэ нөхцөл байдалд нийцүүлэхийн тулд яаж өөрчлөх вэ гэдэг асуулт юм.

Инфляцын зорилт нь олон орны хувьд хүлээлтийг тогтвортжуулах, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр амжилттай хэрэгжиж ирсэн№. Гэвч зөвхөн энэ хүрээнд зорилтоо тодорхойлох нь санхүүгийн тэнцвэргүй байдал, системийн эрсдэл зэрэг өргөн хүрээний эмзэг байдлыг шийдвэрлэхэд хангалтгүй байж болзошгүй бид улам их анзаарч байна. Олон улсын төлбөр тооцооны банк (BIS)-ийн Клаудио Борио болон бусад олон шинжээчийн онцолж байгаачлан№, санхүүгийн тогтвортой байдлын асуудлыг бодлогын хүрээнд системтэйгээр тусгаж өгөх нь улам бүр чухал ач холбогдолтой болж байна.

Олон улсын жишигт төв банкнуудын мандат зөвхөн үнийн тогтвортой байдлаар хязгаарлагдахгүйгээр, эдийн застийн өсөлт, бүрэн ажил эрхлэлт, санхүүгийн тогтвортой байдал зэрэг өргөн хүрээнд чиглэж байна. Өнөөгийн төвөгтэй орчинд төв банкнуудад эдийн засгийн өргөн хүрээний тэсвэртэй байдлыг дэмжих үүрэг улам ихээр нэмэгдэж байгаа ч, энэ нь сөрөг үр дагавар дагуулах эрсдэлтэй гэдгийг анхаарч, харилсан зөрчилдөх бодлогын зорилтуудын хооронд тэнцвэрийг нарийн хангахын хамт төв банканд итгэх итгэлийг

хадгалахыг шаардаж байна.

Үүний зэрэгцээ бидний ашигладаг бодлогын хэрэгсэл одоогийн сорилтуудыг шийдвэрлэхэд бүрэн тохиromжтой эсэхийг нягталж үзэх шаардлагатай. Зөвхөн хүүгийн түвшин ба санхүүгийн тайланд тулгуурласан бодлогоор асуудлыг шийдэх нь хангалтгүй байж болох тул макро зохистой бодлогын арга хэмжээ, хөрвөх чадварын хэрэгслүүд болон илүү өргөн хүрээний бодлогын хослол нь улам бүр чухал нэмэлт хэрэгсэл болж байна.

Мөн хамгийн чухал нь, мөнгөний бодлогоор дамжуулж юу хийх боломжтой, юу хийж чадахгүйг ил тод, бодитоор ойлгох ёстой. Төв банкны үүрэг, хязгаарлалтыг шударга бөгөөд ил тод мэдээлэх нь олон нийтийн итгэлийг хадгалахад зайлшгүй шаардлагатай юм.

b) Бодлогын хамрах хүрээг сайжруулах

Төв банкны мандатыг эргэн хараахас гадна, энэ шинэ орчинд үр ашигтай ажиллахын тулд бодлогын хамрах хүрээг мөн сайжруулах хэрэгтэй.

Гол сорилт бол нийлүүлэлтийн шок нь түр зуурын эсвэл урт хугацаанд үргэлжлэх эсэхийг ялгах явдал бөгөөд энэ нь урьдчилж үнэлэхэд ихээхэн хүндрэлтэй байдаг. Мөн хоёрдох шатны нөлөө болон түүний инфляцын хүлээлтэд үзүүлэх нөлөөг тасралтгүй хянах нь улам

бүр чухал болж байна.

Эдгээр сорилтуудыг даван туулахын тулд дараах гурван үндсэн чиглэлд сайжруулалт хийх шаардлагатай: **өгөгдөл, шинжилгээний арга хэрэгсэл, мөн олон нийттэй харилцах харилцаа.**

Нэгдүгээрт, өгөгдөл буюу **дата.** Найдвартай бөгөөд цаг хугацааны хоцрогдолгүй өгөгдөл нь сайн бодлого боловсруулах үндэс суурь болдог. Гэвч ихэнх орон, ялангуяа жижиг болон хөгжиж буй эдийн засгтай орнууд мэдээллийн хязгаарлалт одоог хүртэл тулгарсаар байна. Тиймээс бодит цагийн үзүүлэлтүүд, өндөр давтамжтай өгөгдөл болон өргөн цар хүрээтэй хяналтын хэрэгслүүдийг бэхжүүлэх нь улам бүр чухал болж байна. Үүнд статистикийн байгууллага, олон улсын түншүүд болон бусад төв банкнуудтай хамтран ажиллах нь зайлшгүй шаардлагатай юм.

Хоёрдугаарт, шинжилгээний арга хэрэгсэл. Уламжлалт загвар, арга хэрэгсэл нь өнөөгийн төвөгтэй нийлүүлэлтийн талын динамикийг бүрэн тусгаж чадахгүй байж болзошгүй. Үүнийг нөхөхийн тулд нөхцөл байдлын - сценари анализ, мэдрэг чанарын үнэлгээ, агентад суурисан загварчлал, машин сургалтын арга зэрэг шинэ аргачлалуудыг ашиглах нь үнэтэй цэнэтэй нэмэлт болж чадна. Эдгээр чадавхыг бий болгох нь

боловсон хүчин болон системийн аль алинд хөрөнгө оруулалт шаарддаг.

Гуравдугаарт, олон нийттэй харилцах харилцаа. Тодорхой бус байдал давамгайлсан нөхцөлд үр дүнтэй харилцаа улам чухал болдог. Энэ нь зөвхөн бодлогын шийдвэрүүдийг тайлбарлахаас гадна, хүлээлтийг тогтвортжуулах, итгэлийг хадгалахад чиглэгддэг. Эрсдэл, хязгаарлалтууд болон тодорхой бус байдлыг ил тод мэдээлэх нь зайлшгүй шаардлагатай юм.

с) Мөнгөний болон төсвийн бодлогын уялдаа холбоо

Мөнгөний хэрэгслүүдээс гадна нийлүүлэлтийн талын шокод хариу үйлдэл үзүүлэхдээ мөнгөний болон төсвийн бодлогын уялдаа холбоо бас нэгэн чухал хүчин зүйл болдог.

Худалдааны тасалдал, цар тахал, геополитикийн хурцадмал байдал зэрэг нийлүүлэлтийн талын шокт хариу үйлдэл үзүүлэхдээ бодлого хоорондын уялдаа холбоог бодолцох нь зайлшгүй шаардлагатай юм. Зөвхөн мөнгөний бодлогоор өнөөгийн тулгамдсан бүх сорилтыг бүрэн шийдвэрлэх боломжгүй. Судалгаа, төлөвлөлт сайтай төсвийн арга хэмжээ нь чухал нэмэлт үүрэг гүйцэтгэж чадна.

Үүний зэрэгцээ, улс төр, геополитикийн дарамт нэмэгдсэн энэ үед төв банкны хараат бус байдлыг хангах нь онцгой

чухал болж байна. Төсвийн байгууллагуудтай бүтээлч хамтын ажиллагааг хангахдаа институцийн бие даасан, хараат бус байдлаа хадгалж, тохирсон тэнцвэрийг олох нь төв банкнуудын хувьд нийтлэг сорилт юм.

Валютын тогтвортой байдал, хөрөнгийн урсгал, инфляцын динамик гээд бус нутгийн болон дэлхийн түвшинд мэдлэгээ хуваалцаж, хариу арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх нь эдийн засгийн хүндрэлд тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд туслах болно.

Мэдээж, эдгээр асуултууд хялбар биш бөгөөд тохирсон энгийн хариулт байхгүй. Гэхдээ нээлттэй харилцан яриа, туршлага солилцож, бие биесээ суралцах замаар бид энэхүү сорилт бүхий эринд илүү сайн бэлтгэгдэж чадна.

Хамтын ажиллагаагаа ахиулах тусам бид тус тусын санхүүгийн тогтвортой байдлаа хангах, хүндрэлд тэсвэртэй байдлыг бэхжүүлэх, иргэдийн сайн сайхныг дэмжих чадавх улам бүр нэмэгдэнэ.

IV МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ: БАЙГАЛИЙН НӨӨЦ ИХТЭЙ, ЖИЖИГ НЭЭЛТТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

Одоо улс орныхоо талаар өөрийн бодлоо товчон хуваалцья.

Байгалийн баялаг ихтэй, жижиг нээлттэй эдийн засагтай Монгол Улсын хувьд дэлхийн түүхий эдийн зах зээлийн хэлбэлзэл болон гадаад шокт онцгой мэдрэг байдаг. Худалдааны тасалдал болон геополитикийн хурцадмал байдал нь богино хугацаанд манай дотоод эдийн засагт нөлөөлж, инфляцын тогтвортой байдал болон санхүүгийн зах зээлийн дарамтыг нэмэгдүүлдэг.

Энэ утгаараа олон улсын хамтын ажиллагаа, харилцан яриаг сайжруулах нь онцгой үнэ цэнэтэй юм. Хуваагдмал бөгөөд тодорхойгүй байдал давамгайлсан өнөөгийн дэлхийд төв банкнуудын хооронд шууд харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал билээ.

V ХЭЛЭЛЦЭХ СЭДВҮҮД: ДӨРВӨН ХУРАЛДААНЫ АСУУДЛУУД

Хурлыг албан ёсоор эхлүүлэхээс өмнө өнөөдрийн хэлэлцэх дөрвөн сэдвийн талаар эргэцүүллээ товчон хуваалцахыг хүсэж байна.

Эхлээд бид дэлхийн эдийн засагт гарч буй өөрчлөлтөд нөлөөлж буй худалдааны хэлбэлзэл болон үнэ цэнийн сүлжээний дахин зохион байгуулалтын асуудлыг авч

үзнэ. Эхний салбар хуралдаан нь геополитик болон эдийн засгийн улам бүр нэмэгдэж буй хуваагдлын улмаас дэлхийн үйлдвэрлэлийн сүлжээ хэрхэн өөрчлөгдж байгаа талаар, энэ нь худалдааны цочрол болон сааталд хэрхэн нөлөөлж байгааг Азийн болон бусад нээлттэй эдийн засгуудын жишээн дээр хэлэлцэх болно.

Хоёр дахь салбар хуралдаан
өнөөдөр төв банкнуудад тулгарaad буй гол асуудал болох тариф болон дараалан үүсэж буй нийлүүлэлтийн шокуудын нөхцөлд мөнгөний бодлогыг хэрхэн хэрэгжүүлэх тухай асуудлыг хөндөнө. Энэ хүрээнд богино болон урт хугацааны шокуудыг хэрхэн ялгах, бодлогын хүрээг хэрхэн шинэчлэх, мөн инфляц дотоод бус гадаад хүчин зүйлсээс ихээхэн хамаарч байгаа энэ үед иргэдийн итгэлийг хэрхэн хадгалах талаар чухал байр суурийг сонсох болно.

Гурав дахь салбар хуралдаан
нь хэлэлцүүлгийг өргөтгөн,

ногоон шилжилт, хиймэл оюун ухаан, дижиталчлалын макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг судална. Эдгээр хүчин зүйлс хөдөлмөрийн зах зээлд, бүтээмжид, цаашлаад нийгэмд хэрхэн нөлөөлж байгааг авч үзэхийн зэрэгцээ бодлого тодорхойлогчид технологийн өөрчлөлт, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг шударга, өргөн хүрээнд эдийн засгийн боломжуудыг бүрдүүлэх байдлаар төлөвлөх шаардлагатайг голлон ярилцана.

Эцэст нь, **дөрөвдүгээр салбар хуралдаан** нь ирээдүйн дэлхийн эдийн засаг, санхүүгийн тогтолцооны боломжит нөхцөл байдал, хувилбаруудыг хэлэлцэх болно. Геополитикийн өрсөлдөөн эрчимжиж, эдийн засгийн үндсэрхэг үзэл нэмэгдэж буй энэ үед бид дэлхийн санхүүгийн засаглал, олон талт тогтолцоо, мөн тогтвортой байдлыг хангахад төв банкнуудын үүрэг ямар байхыг эргэцүүлэх шаардлагатай

юм.

Эдгээр салбар хуралдаануудаас төрөн гарах үнэт санал санаачилга, гүн ойлголтуудыг хамтдаа сонсож, нээлттэй хэлэлцэн, мэдлэг, ойлголтоо ахиулна гэдэгт миний бие итгэлтэй байна.

Төгсгөлд нь, эрхэм оролцогчид, хүндэт зочид Та бүхнийг Монгол Улсад тавтай морилж, таалан саатахыг чин сэтгэлээсээ урьж байна. Манай орны өвөрмөц соёл, эртний түүх, арвин уламжлал, элгэмсэг зочломтгой занг өөрийн биеэр мэдэрч үзэхийг уриалж байна. Энэ хурлын үеэр өрнөх үр дүнтэй хэлэлцүүлгүүдийн хажуугаар Та бүхний энэ удаагийн айлчлал мэргэжлийн хувьд өгөөжтэй, хувь хүний хувьд дурсамж дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Анхаарал тавьж сонссон Та бүхэнд баярлалаа!



I ХУРАЛДААН

“ДЭЛХИЙН ХУДАЛДАА БА ӨРТГИЙН СҮЛЖЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ: ХУДАЛДААНЫ ШОК, ХУДАЛДААНЫ ТАСАЛДАЛ, ХУДАЛДААНЫ ЧИГЛЭЛ ӨӨРЧЛӨГДӨХ НЬ”

Чиглүүлэгч:

ТИГРАН ПОГОСЯАН (TIGRAN Poghosyan) - ОУВС-ийн Монгол дахь Суурин төлөөлөгч

Илтгэгч:

АНДРЕЙ РАДУЛЕСКУ (ANDREI Rădulescu) - Румын улсын ШУА-ийн Дэлхийн эдийн засгийн хүрээлэнгийн ахлах судлаач

ЖОН ВУ КАН (JONG WOO Kang) - Азийн хөгжлийн банкны Бүс нутгийн хамтын ажиллагаа, интеграцциллын хэлтсийн захирал

ПРАЧИ МИШРА (PRACHI Mishra) - БНЭУ-ын Ашока их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор

НИНЖБАТ УУГАНБААТАР - Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга

ЖАН ЛИЧИН (ZHANG Liqing) - БНХАУ-ын Санхүү, эдийн засгийн төв их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор

Энэхүү хэлэлцүүлгээр дэлхийн худалдааны бүтэц хэрхэн өөрчлөгджэх буйг авч үзэхийн зэрэгцээ геополитикийн хурцадмал байдал, худалдааны шок, эдийн засгийн дахин хуваарилалт зэрэг хүчин зүйлс нь олон улсын худалдааны ургалд хэрхэн гүнзгий нөлөө үзүүлж байгааг онцлон, дараах агуулгын хүрээнд хэлэлцлээ.

- АНУ-ын тарифын өсөлт, худалдааны бодлого нь дэлхийн өртгийн сүлжээ буюу ялангуяа, Ази тивд томоохон тасалдал, доголдол үүсгэж байна.
- Монгол, Энэтхэг, Хятад зэрэг орнууд шинэ нөхцөл байдал зохицон, эдийн засгийн шинэ бодлого боловсруулахын зэрэгцээ худалдааны шинэ арга зам, түншлэлийг эрэлхийлж байна.
- Дотоодын үйлдвэрлэл болон аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих бодлого нь уламжлалт худалдааны бодлогоос илүү ач холбогдолтой болж, эдийн засагт үндсэн тулгууруудын нэг болж байна.
- Гадаад худалдааны чиг хандлагад тодорхойгүй байдал давамгайлж байгаа энэ үед дэлхийн эдийн засгийн төлөв байдал бүс нутгийн төвлөрөл рүү чиглэж болзошгүй байна.
- Санхүүгийн тогтолцоо ч мөн өөрчлөгдж байгаа бөгөөд АНУ-ын доллар төвтэй тогтолцоо аажмаар байр сууриа алдаж, Хятадын юань зэрэг өөр валютуудын хэрэглээ олон улсад өсөн нэмэгдэж буй тухай

Эдгээр агуулгыг хөндсөн хэлэлцүүлгийн эцэст дэлхийн худалдаа үндсээрээ шинэ түвшинд шилжиж байгааг онцолж, үүсэж буй эрсдэл мөн боловж бүрд улс орнууд оновчтой стратеги, уян хатан, шинэлэг хандлагаар хариу өгөх шаардлагатай гэж илтгэгчид дүгнэсэн юм.

Онцлох байр суурь**ЖОН ВУ КАН**

Азийн хөгжлийн банкны Бус нутгийн хамтын ажиллагаа, интеграцчилын хэлтсийн захирал

“Ази тивд худалдааны шилжилт хамгийн хүчтэй мэдрэгдэж байна. Вьетнам, Индонез, Энэтхэг зэрэг орон худалдааны урсгалын өөрчлөлтийг ашиглаж, үйлдвэрлэл болон хөрөнгө оруулалтыг эрчимтэй татаж эхэллээ.”

АНУ-ын тарифын өсөлт нь зөвхөн экспортлогч орнуудад шууд нөлөөлөөд зогсохгүй, нийлүүлэлтийн сүлжээгээр холбогдсон бүх эдийн засагт дам нөлөө үзүүлж байна. Монгол Улсын хувьд АНУ-тай худалдааны эргэлт харьцангуй бага ч, Хятад улстай эдийн засгийн хамаарал өндөр тул “Дам цохилт” авах эрсдэл их байна. Тиймээс бодлого боловсруулахдаа шууд бус нөлөөллийг нарийвчлан үнэлж, бус нутгийн хэлэлцээр болон шинэ түншлэлийг чухалчлах, өртгийн сүлжээний аль шатанд оролцож буйгаа нарийн тооцох шаардлагатай.

**Н.УУГАНБААТАР**

Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга

“Улсторчдийн сэтгэл хөдлөлд үндэслэсэн шийдвэрүүд нь эдийн засгийн загварчлал болон бодлого боловсруулалтад хангалттай тусгагддаггүй нь гол анхаарах асуудлуудын нэг юм.”

Монголын эдийн засгийн бүтэц энгийн бөгөөд түүхий эдэд хэт тулгуурладаг учраас гадаад худалдаа нь геополитикийн өөрчлөлтөд эмзэг. АНУ-ын тариф, түүхий эдийн үнийн савлагаа нь төсөв, мөнгөний бодлогод дарамт үүсгэж байна. Ковид-19 цар тахал нэг талаар иргэдийн орлогод нөлөөлсөн ч, нөгөө талаар логистикийн саатал нь бодлогын уялдаа холбоог алдагдуулж, зөрччлийг хурцатгасан. Эндээс “Хурдтай үр дүн” хүлээсэн улстөржилт нь урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх бодлого, шийдвэрт сөргөөр нөлөөлж байна.

**ПРАЧИ МИШРА**

БНЭҮ-ын Aishoka их сургуулийн Эдийн засгийн тэнхимийн профессор

“Тарифаас илүүтэйгээр тодорхой бус байдал нь худалдааны шинэ дэг журамд хамгийн том сорилт болон ирж байна”

АНУ-ын тарифын савлагаа, инфляц, зах зээлийн хэлбэлзэл нь компани, хэрэглэгчийг шийдвэрээ хойшлуулахад хүргэж байна. Энэтхэг улсын эдийн засаг аажмаар сэргэж буй ч хувийн хөрөнгө оруулалт сул, бус нутгийн орлогын ялгаа их хэвээр байна. Гэсэн хэдий ч хүн ам залуу, хөдөлмөрийн нөөц элбэг байгаа нь Энэтхэгт үйлдвэрлэлээ өргөжүүлэх том боломжийг олгож байна.



“Цорын ганц тодорхой байгаа зүйл бол тодорхой бус байдал.”

Евро бүсийн өрсөлдөх чадвар огцом доройтож, нэг хүнд ногдох ДНБ нь АНУ-тай харьцуулахад 54 хувьд хүрсэн нь сүүлийн 40 жилийн доод үзүүлэлт юм. Хөдөлмөрийн бүтээмж, дижитал эдийн засгийн эзлэх хувь, хөрөнгийн зах зээлийн хөгжил дорой байгаа нь гол саад гэж үзэж байна. Хэрэв суурь шинэчлэл хийж чадахгүй бол Европ “ногоон музей” болох эрсдэл өндөр. Харин боловсрол, нийгмийн тогтолцоо, хөрөнгийн менежментийн давуу талаа ашиглавал сэргэлт бий болох боломжтой.

АНДРЕЙ РАДУЛЕСКУ
Румын улсын ШУА-ийн
Дэлхийн эдийн засгийн хүрээлэнгийн
ахлах судлаач



“Бид зуун жилд байгаагүй өндөр тарифыг урт хугацаанд туулж магадгүй.”

АНУ-ын өндөр тариф нь алдагдлаа бууруулах, төсвийн орлогоо нэмэгдүүлэх, дотоод үйлдвэрлэлийг сэргээх бодит шийдэл биш, харин Хятадаас “Эрсдэлээ салгах” улс төрийн зорилготой арга хэмжээ юм. Амдоллар ойрын хугацаанд ноёрхлоо хадгална. Гэхдээ урт хугацаанд дэлхийн валютын системд шинэ тэнцвэр зайлшгүй төлөвшихөөр байна. Ренминби буюу Юанийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд БНХАУ санхүүгийн зах зээлээ ил тод, нээлттэй болгох, оффшор юанийн зах зээл болон шинэ финтек шийдлүүдийг өргөжүүлэх шаардлагатай.

ЖАН ЛИЧИН
БНХАУ-ын Санхүү, эдийн засгийн
төв их сургуулийн Эдийн засгийн
тэнхимийн профессор

How Central banks respond to?

- Balancing inflation control and growth risk
- Inflation expectations
- Communication and forward guidance
- Monitoring financial stability



II ХУРАЛДААН

“ТАРИФ БА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОКИЙН ҮЕИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГО”

Чиглүүлэгч:

БАТДЭЛГЭР ТҮВШИНТӨГС

Монгол Улсын Их Сургуулийн,
Эдийн засгийн тэнхимийн
профессор

Илтгэгч:

БАЯРСАЙХАН БАЯРДАВАА -

Монголбанкны Ерөнхий эдийн
засагч / Мөнгөний бодлогын
газрын захирал

ДОНГ ЧҮЛ ЧО (DONG CHUL Cho)

- БНСУ-ын Хөгжлийн Хүрээлэн
(KDI)-ийн Ерөнхийлөгч

МИРОСЛАВ СИНГЕР (MIROSLAV

Singer) - Чехийн Төв Банкны
Ерөнхийлөгч асан

СОНЕР БАСКАЯ (SONER Baskaya)

- Глазгогийн Их Сургууль, Эдийн
засгийн ухааны профессор

Энэхүү хэлэлцүүлгийн үеэр төв банкнууд эдийн засгийн тасалдал болон нийлүүлэлтийн шокийн үед хэрхэн үр дүнтэй хариу үзүүлж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах талаар хэлэлцэв. Энэ хүрээнд;

- Нийлүүлэлтийн шок нь мөнгөний бодлогын хувьд туйлын төвөгтэй сорилт болдог,
- Эдийн засгийн тодорхойгүй байдал давамгайлсан үед инфляцын хүлээлтийг удирдахад ач холбогдол өгөх нь маш чухал,
- Төв банкнууд нь бодлогын шийдвэр гаргахдаа 1/ эдийн засгийн өсөлт, 2/ инфляц, 3/ төв банканд итгэх итгэл гэсэн тэнцвэрийг хадгалахад анхаарах ёстой гэсэн агуулгын хүрээнд хэлэлцэж, төв банкны стратегийн чиг хандлагыг доорх байдаар онцлон тодорхойлов:
- Ил тод, ойлгомжтой харилцаа, мэдээлэл түгээх урсгалыг нэмэгдүүлэх,
- Бодлогын уян хатан байдлыг хадгалах,
- Инфляцын хүлээлтийг тогтоон барих,
- Эдийн засгийн шинжилгээ, судалгааг илүү үр дүнтэй, нарийн нягт болгохын төлөө илүү их дайчлах,
- Төв банканд итгэх итгэлийг бий болгох, бэхжүүлэхэд анхаарвал зохино гэсэн юм.

Мөн хэлэлцүүлгийн үеэр хөгжиж буй эдийн засагтай орнуудад тулгарч буй дараах бэрхшээлийг онцлов.

- Төсвийн давамгай байдал (fiscal dominance),
- Давтамж нь ихсээд буй эдийн засгийн хүндрэл,
- Инфляцын зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх гэх мэт.

Хурлын эцэст төв банкнууд богино хугацааны эдийн засгийн цочролд хариу өгөхдөө уян хатан, ил тод байдлыг баримтлах нь зохимжтой бөгөөд урт хугацааны эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлого баримтлах ёстой гэсэн нэгдсэн зөвлөмжийг гаргалаа.

Онцлох байр суурь



ДОНГ ЧУЛ ЧО
БНСУ-ын Хөгжлийн Хүрээлэн
(KDI)-ийн Ерөнхийлөгч

"Олон нийтийн итгэлийг хүлээсэн төв банк богино хугацааны уян хатан бодлого явуулах боломжтойгоос гадна урт хугацааны зорилтоо биелүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг"

Төв банкны хувьд зөвхөн тухайн жилийн инфляцын түвшинг хянахаас гадна урт хугацааны инфляцын хүлээлтийг тогтвортой барих нь чухал зорилт болдог. Үүний тулд төв банк амлалтдаа туштай байж, зөвхөн хэлэх бус, үйлдлээрээ нотлох хэрэгтэй. Мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхд анхаарах гол зарчим бол: "Хэлснээ хий, хийснээ хэл"



МИРОСЛАВ СИНГЕР
Чехийн Төв Банкны
Ерөнхийлөгч асан

"Улс төрийн дэмжслэгийг байж л байдаг зүйл гээж эндүүрч болохгүй"

Цаг хугацааны явцад зайлшгүй тулгарах сорилтуудад бэлэн байхын тулд урьдчилан итгэлцлийг бүрдүүлж, тохирсон арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Харин ямар нэгэн бодит шаардлага байхгүй тохиолдолд мөнгөний бодлогын хамрах хүрээнээс гадуурх үйлдэл хийхээс зайлсхийх хэрэгтэй. Өнөөгийн хямралын үед улс төрчид дэмжлэг үзүүлж болох ч энэ нь цаашид үргэлжилсээр байх болно гэж эндүүрч болохгүй.



СОНЕР БАСКАЯ
Глазгогийн Их Сургууль,
Эдийн засгийн ухааны профессор

"Монгол Улсад хамаарах нэг чухал зүйл бол худалдаа, санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, ингэснээр эдийн засгийн тэсвэртэй байдлыг хангаж чадна"

Санхүүгийн тогтвортой байдлын ачааллыг зөвхөн төв банк үүрэх боломжгүй. Зарим улс хөрөнгийн урсгалыг зохицуулах, уян хатан татварын бодлого хэрэглэх гэх зэргээр нэмэлт хэрэгслийдийг ашиглаж ирсэн. Түүнчлэн, сангийн бодлого ч төв банкны бодлогыг нөхөх чадамжтай байх шаардлагатай. Үүний тулд тогтвржуулах сангуд, эрэлтийн эсрэг татварын зохицуулалт (жишээлбэл, Турк цахилгааны үнэд ногдуулдаг татварыг хямралын үед бууруулдаг гэх мэт) хэрэгтэй. Монгол Улсад хамаарах нэг чухал зүйл бол худалдаа, санхүүгийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, ингэснээр эдийн засгийн тэсвэртэй байдлыг хангаж чадна.



Б.БАЯРДАВАА
Монголбанкны өрөнхий эдийн засагч
Мөнгөний бодлогын газрын захирал

“Хэдийгээр нийлүүлэлтийн шокоор инфляц өдөөгдсөн ч Төв банк инфляцыг хянах эрмэлзлээ харуулж, инфляц буурах итгэлийг бэхжүүлэхийн тулд бодлогын хүүг нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.”

Хэрэв нийлүүлэлтийн шокоос үүдэлтэй инфляц удаан хугацаанд үргэлжилбэл, олон нийт ирээдүйд үнэ тасралтгүй өснө гэх хандлагатай болж, цалин нэмэх, бараа үйлчилгээний үнэ дагаад өсөх зэргээр улам бүр даамжирдаг. Энэ нь хадгаламж эзэмшигчид болон иргэдийн худалдан авах чадварыг бууруулж, тэдэнд сөргөөр нөлөөлдөг. Монгол Улсын хувьд, сүүлийн хоёр жилийн хугацаанд дээрх нөхцөл байдал тод ажиглагдаж байна. Иймээс төв банк инфляцыг бууруулах, итгэлийг хадгалахын тулд бодлогын хүүг нэмэгдүүлэх алхам хийдэг.

- Maturing policy frameworks
 - Flexible exchange rate regimes
 - Inflation targeting
 - Fiscal frameworks
- Lower vulnerability to shocks
 - Reduced FX debt, local currency sovereign debt
 - Large FX reserves buffers
 - Deeper domestic financial systems

Өдрийн цайны үеэрх танилцуулга

“НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОКОД ХАРИУЧЫН ҮЗҮҮЛЭХ ТӨСВИЙН БОДЛОГО”

Чиглүүлэгч:

ОЧИРХҮҮ ЭРДЭМБИЛЭГ УИХ-ЫН
даргын Эдийн засгийн асуудал
хариуцсан зөвлөх

Илтгэгч:

МИТАЛИ ДАС (MITALI Das)
- Олон Улсын Валютын Сан
(ОУВС)-ийн, Төсвийн бодлогын
хэлтсийн зөвлөх

Энэхүү хуралдаанд ОУВС-ийн Төсвийн бодлогын хэлтсийн зөвлөх Митали Дас илтгэл танилцуулж, түүнтэй УИХ-ын даргын Эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх О.Эрдэмбилэг нийлүүлэлтийн шок (нийлүүлэлтийн гэнэтийн тасалдал, хомсдол)-д хэрхэн үр дүнтэй төсвийн бодлогоор хариу үзүүлэх талаар ярилцсан юм. Тэд энэ үеэр хөгжиж буй зах зээлтэй орнуудын хувьд эдийн засгийн сорилтод хэрхэн оновчтой хариу өгөх асуудлыг хөндлөө. Ялангуяа, төсвийн бодлогын оновчтой байдал нь эдийн засагт тулгарч буй шинэ сорилтуудыг хүндрэл баатай даван туулахад чухал нөлөө үзүүлнэ гэдэгт санал нэгдэцгээж байв. Хэлэлцүүлгийн үеэр дараах асуудлуудыг онцоллоо. Үүнд:

ТӨСВИЙН БОДЛОГЫН СТРАТЕГИЙН ХҮРЭЭНД:

- Эдийн засгийн шокийн үед зорилтот бүлэгт чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нь чухал,
- Тогтвортой нөхцөл байдалд хурдан дасан зохицох уян хатан төсвийн хүрээ шаардлагатай,
- Төсвийн сахилга батыг хадгалахтай зэрэгцэн нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах зайлшгүй хэрэгцээ бий.

ЭДИЙН ЗАСАГТ ТУЛГАРААД БҮЙ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОКИЙГ ТАНИХЫИН ТУЛД:

- Төрөл бүрийн нийлүүлэлтийн шокийн (цар тахал, геополитикийн эрсдэл, нөөцийн хомсдол гэх мэт) шинжилгээ хийх,
- Нийлүүлэлтийн шок нь уламжлалт эрэлтийн шокоос юугаараа өөр болохыг ойлгох,
- Эдийн засгийн системд бүтцийн эмзэг байдал байгаа эсэхийг тодруулах.

ХӨГЖИЖ БҮЙ ЗАХ ЗЭЭЛД ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ:

- Үр дүнтэй бодлого хэрэгжүүлэхэд төсвийн орон зай хомс байна,

- Төрийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн сэргэлтэд учирдаг хязгаарлалтууд,
- Баялгийн сангийн бүтэц, зориулалтыг сайжруулах хэрэгтэй зэргийг онцлов. Бодлогын зөвлөмж:
- Ил тод, хариуцлагатай төсвийн дүрэм боловсруулах,
- Автомат тогтвортжуулагч механизмуудыг (жишээ нь ажилгүйдлийн тэтгэмж) бий болгох,
- Баялгийн сангийн үйл ажиллагааг илүү уян хатан болгох,
- Хямралын үед чухал хөрөнгө оруулалтуудыг хамгаалах, нийгмийн хамгааллын бодлогыг илүү зорилтот бүлэг рүү шилжүүлэх.

ИРЭЭДҮЙД ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТУЛД:

- Илүү уян хатан эдийн засгийн бодлогын хүрээг бий болгох,
- Шокийг шингээх чадварыг сайжруулах
- Улс орнууд эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх хэрэгтэй гэв.

Онцлох эшлэл



МИТАЛИ ДАС
Олон Улсын Валютын
Сангийн Төсвийн бодлого
хариуцсан зөвлөх

“Хөгжиж буй орнуудад энэ нөхцөл байдал түр зуурын удаашрал бус, харин эдийн засгийн бүтээмжид учирсан байнгын хохирол болсныг харуулж байна.”

Судалгааны үр дүнгээс харахад цар тахлын уналтын дараа хөгжингүй орнууд эдийн засгийн гарцын алдагдлаа нөхсөн бол хөгжиж буй улс орнуудын хувьд эдийн засгийн өсөлтийн чиг хандлага нь өөрчлөгджэх, гарцын алдагдал нь хэвээр үлджээ. Үүнийг “мөчлөг нь өөрөө тренд болсон” буюу эдийн засгийн шок нь түр зуурын хэлбэлзэл бус, суурь чиг хандлагыг өөрчилсөн.

Гол шалтгаан нь нийлүүлэлтийн болон эрэлтийн хос шок бодлогын хариу арга хэмжээний онцлог, эдийн засгийн салбарын ялгаатай байдалтай холбоотой юм. Цаашид хөгжиж буй орнууд эдийн засгийн шокийг даван туулах чадвараа нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, ил тод тогтолцоо бүрдүүлэх, нийгмийн халамжийн зорилтот дэмжлэгийг үр дүнтэй хэрэгжүүлэх, чанартай, егөөжтэй хөрөнгө оруулалтыг татах шаардлагатай.



III ХУРАЛДААН

“ХИЙМЭЛ ОЮУН УХААН, ДИЖИТАЛ БОЛОН НОГООН ШИЛЖИЛТИЙН МАКРО ҮР НӨЛӨӨ”

Чиглүүлэгч:

БАТЧУЛУУН АЛТАНЦЭЦЭГ

Үндэсний судалгаа, зөвлөх төв (NRCC), Гүйцэтгэх захирал

Илтгэгч:

АСЯ КОСТАНЯН (ASYA Kostanyan) - “Better Policy Project” төслийн Ерөнхий эдийн засагч

МАТИЛДА ДИМОВСКА

(MATILDA Dimovska)- Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Суурин төлөөлөгч

РЭКВОН ЧУН (RAEKWON Chung) - Бан Ки-Мүний Тогтвортой Ирээдүйн Сангийн Удирдах зөвлөлийн гишүүн

СОННЕДУ МОХАНТИ (Sopnendu Mohanty) - Глобал Санхүү, Технологийн Сүлжээ (GFTN)-ийн Гүйцэтгэх захирал

Технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед, хиймэл оюун ухаан (AI), дижитал шинэчлэл, тогтвортой хөгжил нь Монголын эдийн засгийн ирээдүйд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг уг хуралдаанаар хэлэлцлээ. Сэдвийн хүрээнд хөгжиж буй эдийн засагтай манайх шиг улсад технологийн дэвшилийг ашиглан бүтээмжээ нэмэгдүүлэх, ногоон шилжилт хийх боломжуудын талаар оролцогчид байр сууриа илэрхийлэв.

АИ БА БҮТЭЭМЖИЙН ӨСӨЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТАЛААР:

- Төв банкууд AI ашиглан бүтээмжээ нэмэгдүүлж, ажлын үр дүнгээ ахиулах боломжтой,
- AI хэрэгслээр дамжуулан бүтээмжийг 60% хүртэл өсгөх нөөц бололцоотой,
- Мэдээлэл боловсруулах, тайлгнах, сургалт хийх үйл ажиллагааг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх боломж байгаа зэргийг тус тус онцлов.

Монгол Улс е-засгийн хөгжлөөр дэлхийд 46-р байранд эрэмбэлэгдэж байгаа ч дижитал шилжилтийн хүрээнд дараах сорилтууд байна гэж үзэв. Үүнд:

- Дижитал дэд бүтцийн тэгш бус хүртээмж
- Мэдээллийн технологийн мэргэжилтний хомсдол (27,000 мэргэжилтэн хэрэгтэй)
- Ёс зүйтэй AI хөгжүүлэлтийн хүрээний дутагдал зэрэг бэрхшээл бий гэдийг онцлов.

Хэдийгээр дижитал хөгжил олон давуу талтай ч энэ нь ажлын байрны хомсдол үүсгэх эрсдэлтэй эсэх нь анхаарал хандуулах шаардлагатай сэдэв юм. Тус хурлаар энэ тухай хөндөхдөө ялангуяа, хөгжиж буй орнуудад ажлын байр багасах төлөвлөх байгаа тул дараах хэд хэдэн байдлаар хариу арга хэмжээ авахыг зөвлөсөн юм. Үүнд:

- Одоо ажиллаж буй ажилтнуудаа сургаж, чадваржуулах
- Шинэ мэргэжилтнүүд бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх,
- Боловсролын системийг шинэчлэх,
- Ёс зүйтэй AI-ийн бодлогын хүрээ боловсруулах гэх мэт.

Тус хуралдаанаар хөндсөн бас нэгэн сэдэв бол ногоон шилжилт ба эдийн засгийн боломжийн тухай байв. Энэ хүрээнд;

- Уур амьсгалын өөрчлөлтийг ачаа биш, эдийн засгийн боломж гэж хүлээн зөвшөөрөх,
- Нүүрстөрөгчийн үнэ тогтоох бодлого (carbon pricing)-г дотооддоо бий болгох,
- Иргэдийн оролцоо ногоон шилжилтэд шийдвэрлэх үүрэгтэй гэдгийг тал бүртээ анхаарах,
- Экологийн татварын шинэчлэл хийх зэрэг асуудлуудыг хөндөв.

Иймд хэлэлцүүлгээр доорх чиглэлээр зөвлөмж гаргав. Үүнд:

- Олон нийтэд зориулсан дижитал дэд бүтцэд хөрөнгө оруулах,
- AI болон ногоон шилжилтийн иж бүрэн стратеги боловсруулах,
- Сургалтын хөтөлбөрүүдэд анхаарч, чадвар хөгжүүлэхийг дэмжих,
- Ногоон санаачилгад иргэдийн оролцоог дэмжих, урамшуулах,
- Тогтвортой хөгжлийг дэмжих бодлогын орчин бүрдүүлэх хэрэгтэй гэсэн зөвлөмжийг өгөв.

Энэхүү хуралдаан нь технологийн болон хүрээлэн буй орчны сорилтуудыг эдийн засгийн өсөлт рүү чиглүүлж болох боломж байгааг онцлов. Үүнийг хийхдээ ёс зүйтэй, хүртээмжтэй, тогтвортой хөгжил-ийг чухалчилсан юм.

Онцлох байр суурь

АСЯ КОСТАНЯН
*"Better Policy Project" төслийн
 Ерөнхий эдийн засагч*

Тэрээр "AI-ийн эрин үед ажлаас халшрах хам шинжээс тэнцвэрт байдал руу шилжих нь" (Shifting gear from burnout to balance in the age of AI) сэдвээр танилцуулга хийсэн. Энэ үеэр Арменийн Төв Банканд хэрэгжүүлсэн FPAS (Forecasting and Policy Analysis System) Mark II системийг танилцуулсан бөгөөд үүнийг COVID-19 цар тахлын дараах тодорхойгүй орчинд бодлогын олон сценариийг авч үзэх, эрсдэлийг ил тод тайлбарлах шаардлагаас үүдэн хөгжүүлсэн байна.

"Бид AI-ийг зөвхөн үр ашигтай хэрэгсэл биш, харин төв банкны ил тод байдал, ажилтнуудын мэдлэг чадвар, урам зоригийг дэмжих ёс зүйтэй хөгжлийн түвш болгон ашиглахыг зорьж байна."

Сүүлийн үед AI-ийг сургалт, код шалгах, илтгэлийн текст боловсруулах, мэдээ тайлагнал зэрэгт үр дүнтэй ашиглаж байгаа бөгөөд Trilateral Research байгууллагатай хамтран төв банкнуудад зориулсан AI хэрэгсэл боловсруулж байна. Энэхүү хэрэгсэл нь оффлайн ажиллах, аюулгүй, ёс зүйтэй байх давуу талтай бөгөөд хэл яриаг текст болгох, график бүтээх, тайлангийн агуулгыг хураангуйлах зэрэг олон боломжийг агуулна.



МАТИЛДА ДИМОВСКА
*Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн
 хөтөлбөрийн Суурин төлөөлөгч*

"AI хүн төрөлхтнийг орлох биш, хүний чадамжийг ахиулахад үйлчлэх ёстой."

Хүний хөгжлийн индекс сүүлийн жилүүдэд цар тахал, өрийн хямрал, ажилгүйдэл, худалдааны зөрчил зэрэг шалтгаанаар зогсонги байдалд орж, хөгжлийн дэвшил хэдэн жил биш хэдэн арван жилээр ухарсан. Монгол Улс хүний хөгжлийн индексээр "Өндөр хөгжилтэй орны" ангилалд багтсан ч хөгжлийн загвар нь уур амьстгалын өөрчлөлт, уул уурхайн хамаарал, хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөнөөс үүдэн дарамтад ороод байна. Хөдөө орон нутаг дахь дэд бүтцийн ялгаа, ур чадварын дутагдал, Айийн ёс зүй, зохицуулалтын орчны тодорхой бус байдал нь сорилт болж байна. Гэсэн ч Монгол Улсын хувьд хиймэл оюун ухааны хөгжилд чиглэсэн бодлого тодорхой бөгөөд хувийн хэвшил идэвхтэй байгаа нь эерэг хандлага боловч ур чадварын хомсдол, дэд бүтцийн тэгш бус хүртээмж, Айийн ёс зүй, хууль эрх зүйн орчны тодорхой бус байдал зэрэг сорилтууд тулгарсаар байна.



СОПНЕНДУ МОХАНТИ
Глобал Санхүү, Технологийн Сүлжээ (GFTN)-ийн Гүйцэтгэх захирал

"AI хүн төрөлхтнийг орлох биш, хүний чадамжийг ахиулахад үйлчлэх ёстой."

"AI нь эдийн засгийн үйл ажиллагаанд хүний хийж буй бүхий л үйл явцыг дуурайн гүйцэтгэхээр бүтээгдсэн бөгөөд цаашид энэ чадвар улам сайжирна. Харин бид үүнд хэрхэн бэлдэх вэ гэдэг л асуулт үлдэж байна."

AI нь хүний үйл ажиллагааг дуурайж, хөдөлмөрийн зах зээлд томоохон өөрчлөлт авчирна. Одоогоор олон ажлын байр алдагдаж байна, гэхдээ зохицуулалт, ёс зүйгээр AI-ийг хянах нь шинэ ажлын байр бий болгох боломж юм. AI, дижитал шилжилт, токенжуулалт нь хэрэглэгчийн үйлчилгээ болон эдийн засгийн бүтэц, бүтээгдэхүүн, үйлчилгээг шинэчилж, ногоон шилжилт тогтвортой хөгжлийн шаардлагыг нэмэгдүүлнэ. Дижитал дэд бүтэц сайн хөгжсөн орнууд энэ өөрчлөлтийг амархан давах магадлалтай. Ирээдүйд боловсролыг шинэчлэх, хүмүүсийг шинэ ур чадварт сургах нь хамгийн чухал сорилт болно.



РАЙКВОН ЧҮН БАН КИ
Мундийн Тогтвортой Ирээдүйн Сангийн
Удирдах зөвлөлийн гишүүн

"Уур амьсгалын өөрчлөлтийг эдийн засгийн зардал, дарамт гэж харах хандлагаа өөрчилж чадвал, энэ нь ажлын байр бий болгох, эдийн засгийг өсгөх боломж болно."

Нүүрстөрөгчийн үнэ тогтоо замаар сэргээгдэх эрчим хүчийг эдийн засгийн хувьд үр ашигтай болгох боломжтой. Үүний тулд хүн амын орлогын татварыг аажмаар багасгаж, нүүрстөрөгчийн татвар нэвтрүүлэх "Экологийн татварын шинэчлэл" хийх боломжтой. Ийм шинэчлэл нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлт, ажлын байр бий болгоход хувь нэмэр оруулах боломжтой гэж үздэг. Хэдий ийм өөрчлөлт эдийн засагт дарамт үүсгэх эрсдэлтэй ч, үүнийг үе шаттайгаар хэрэгжүүлэх бодлогын арга замууд бий. Тухайлбал, "нүүрстөрөгчийн нийгмийн өртөг" (SCC)-ийг томоохон хөрөнгө оруулалтын шийдвэрт тусгах замаар ногоон хөгжилд шилжих суuriйг тавьж болно.



IV ХУРАЛДААН

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ТОГТОЛЦООНЫ ЗАМБАРААГҮЙ БАЙДАЛ — ИРЭЭДҮЙН ХУВИЛБАРУУД

Чиглүүлэгч:

МАРК УЗАН (MARC Uzan)

- Бреттон Вудсын тогтолцоог шинэчлэх хорооны Гүйцэтгэх захирал

Илтгэгч:

МАРИ ФАВЕРО (MARIE Favereau,) - Франц дахь

Төв Азийн судалгааны хүрээлэнгийн Захирал

МАРТИН ЭДУАРД

ДЕБУСМАНН (MARTIN Eduard Debusmann) - Швейцарын ЕҮ аудитын компанийн түнш

ПАВЕЛ КОВАЛЕВСКИ (Pawel Kowalewski) - Польш Улсын Төв Банкны, Ахлах зөвлөх

САЮРИ ШИРАИ (SAYURI Shirai) - Азийн хөгжлийн

банкны хүрээлэн (ADBI)-ийн Тогтвортой бодлогын зөвлөх

Хуралдаанд эдийн засаг, түүх, бодлогын чиглэлийн шинжээчид цоролцож, дэлхий даяар урьд байгаагүй тодорхой бус байдал давамгайлж байгаатай холбогдуулан олон улсын эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, хандлагын талаар хэлэлцэв. Уг агуулгын хүрээнд илтгэгчид дараах асуудлуудыг дэвшүүлж, байр сууриа илэрхийллээ.

ГЕОПОЛИТИКИЙН ӨӨРЧЛӨЛТ

- Үр ашигт сууриссан даяаршилаас итгэлцэл ба аюулгүй байдалд төвлөрсөн олон улсын харилцаанд шилжих
- Тариф ба худалдаа нь геополитикийн стратегийн хэрэгсэл болж байна
- Олон туйлт эдийн засгийн хүчиний шинэ тэнцвэр бүрэлдэж байна

ТЕХНОЛОГИЙН ЭРГЭЛТ

- Хиймэл оюун ухаан, автоматжуулалт нь дэлхийн эдийн засгийн хөгжлийг дахин тодорхойлж байна.
- Дижитал валютууд уламжлалт мөнгөний системд сорилт болж байна.
- Глобал өргтийн сүлжээ дахин бүтцийн өөрчлөлтөд орж болзошгүй байна.

БҮС НУТГИЙН СТРАТЕГИ

- АНУ-ын зах зээлээс хараат байдлыг бууруулах оролдлого
- Дотоодын хэрэглээг нэмэгдүүлж, эдийн засгийн тэсвэртэй байдалд анхаарч байна

МӨНГӨНИЙ СИСТЕМИЙН ХУВЬСАЛ

- АНУ-ын долларын геополитикийн төвийг сахисан байр суурь суларч байна
- Алтернатив валютын систем бий болж байна
- Дижитал болон криптовалютын үүрэг нэмэгдэж байна

ГОЛ СОРИЛТУУД

- Эдийн засгийн үндсээрхэг үзлийг удирдан чиглүүлэх
- Технологийн хурдацтай өөрчлөлтөд дасан зохицох
- Үндэсний эрх ашиг, дэлхийн интеграцийн тэнцвэрийг хангах
- Уян хатан эдийн засгийн загваруудыг боловсруулах

Энэ бүхнээс ирээдүйд дэлхийн эдийн засгийн дэг журам нь уян хатан байдал, тэсвэртэй байдал, стратегийн харилцан хамаарлыг чухалчилсан, нарийн төвөгтэй бүтэцтэй байх болно гэж үзсэн бөгөөд эдийн засгийн бодлогын стратеги нь илүү уян хатан алсын хараатай, технологид дасан зохицож, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй гэж зөвлөв.

Онцлох байр суурь**МАРТИН ЭДУАРД**

Дебусманн Швейцарын ЕҮ аудитын
компанийн тунши

“Глобалчлаг дуусаагүй бөгөөд зөвхөн хэлбэрээ өөрчилж, үр ашигийг бус итгэлцэл, аюулгүй байдал, тэсвэртэй байдлыг нэн түрүүнд тавих шинэ дүрэмд шилжсийж байна.”

Нээлттэй эдийн засгийн орон зай багасаж, үүний оронд итгэлцэл, аюулгүй байдалд сууриссан бус нутгийн холбоо, сүлжээ давамгайлах болно. Нөөц валютын тогтолцоо олон төвтэй болж, ам.доллартай зэрэгцэн алт, юань (RMB), криптовалютын хэрэглээ нэмэгдэж байна. Төв банкнуудын үүрэг инфляц болон санхүүгийн тогтвортой байдлыг хангахаас гадна геополитик, ESG (байгаль орчин, нийгэм, засаглал), экспорт импортын хяналт зэрэг шинэ чиг үргүүдийг хамрах магадлалтай боллоо. Хиймэл оюун ухаан ба робот технологи нь орлого, ашигт байдлыг цөөн хэдэн улс оронд төвлөрүүлж, хөгжиж буй орнууд мэдлэг, үйлчилгээний салбарт дэвших боломжкоо алдах эрсдэлтэй. Гэтэл одоогийн тариифын тогтолцоо үйлчилгээний урсгалыг хамгаалж чадахгүй байна. Төв банкнууд мандатаа өргөтгөж, геополитик, нийлүүлэлтийн эрсдэлийг тооцсон шинэ дүр зурагт нийцсэн илүү нэгдмэл, нарийн загвар хэрэгжүүлэх шаардлагатай боллоо. Улс орнуудын хамгийн чухал зорилго нь ирээдүйд ямар ч нөхцөлд тэсвэртэй байж, урьдчилан бэлдэх, олон талт хамтын ажиллагааг тогтвортой хадгалах юм.

**САЮРИ ШИРАИ**

Азийн хөгжлийн банкны хүрээлэн
(ADBI)-ийн Тогтвортой бодлогын
зөвлөх

“Экспортын хөдөлгүүр саарч байгаа энэ үед дотоод эрэлт нь Ази тивийн тогтвортой өсөлтийн жинхэнэ тулхүүр болно.”

БНХАУ-ын асар хүчтэй үйлдвэржилт, АНУ-ын өндөр хэрэглээ хоёрын хооронд үүссэн худалдааны зөрчил тарифыг нэмэгдүүлснээр бус нутаг тэр чигтээ савлаж эхэллээ. Вьетнам зэрэг аж үйлдвэрийн хөгжлөөрөө түргэн өсөж буй орнууд дараагийн “бай” болох эрсдэлтэй. Азид хоёр өөр чөлөөт худалдааны бус (Бус нутгийн эдийн засгийн иж бүрэн түншлэл(RCEP), Номхон далай дамнасан түншлэлийн тухай иж бүрэн, дэвшилтэт хэлэлцээр (CPTPP) нь Ази, Номхон далайн бус нутгийн чөлөөт худалдааг дэмжих зорилготой бус нутгийн худалдааны хэлэлцээрүүд) өргөжиж байгаа ч, нийлүүлэлтийн сүлжээ Хятадаас бүрэн сална гэж найдах аргагүй. Экспорторд хэт түшиглэсэн өнөөгийн загвар энэ мэт тодорхойгүй үед эмзэг болох нь илт байна. Тарифын дарамтыг зөвлөхийн тулд төв банкнууд хүүгээ бууруулж чадна, гэхдээ энэ нь зөвхөн богино хугацаанд амьсгaa авах шийдэл юм. Төсвийн бодлогын хувьд улс бүр аль хэдийн өндөр өртэй болсон учир “крант”аа нээх орон зай бага байгааг санах хэрэгтэй. Үндсэн гарц нь өрхийн хэрэглээг тогтвортой өсгөх явдал. Цалин, нийгмийн хамгаалал, хэрэглэгчийн итгэл, ESG зарчмыг дэмжсэн урт хугацааны шинэчлэл нь Азийг экспортын хараат байдлаас аажмаар салгана.

**ПАВЕЛ КОВАЛЕВСКИ**

Польши Улсын Төв Банкны, Ахлах зөвлөх

“Олон улсын валютын шинэ дэг журам бүрэлдэн буй энэ үед бид дижитал хувьсгал, geopolitikiийн зорчил, мөн төв банкны ноёрхлын эсрэг эсэргүүцэл зэргийг ойлгож, бодит ертөнц ба дижитал орчны зааг дээрх шинэ сорилтод ухаалаг, уян хатан, тэсвэртэй хандлагаар хариу өгөх ёстой.”

Олон улсын валютын системд АНУ-ын доллароос өөр сонголтууд бий болж, Хятад улсын юань чухал өрсөлдөгч болж байна. Хятадын “Бээжингийн зөвшилцөл” нь Вашингтоны зөвшилцлийн алтернатив байж болзошгүй. АНУ-ын долларын давуу тал болох “TINA” (There Is No Alternative) буюу орлох валют байхгүй гэсэн үзэл сүүлийн үед сулрах хандлагатай байна. АНУ-ын дотоод бодлого, олон улсын хандлага нь амдолларын ноёрхлыг сааруулж байгааг анхаарах хэрэгтэй. Европын Холбоо еврог олон улсын түвшинд түлхүү ашиглахыг зорьж байгаа ч эдийн засгийн бүтэц, институцийн сул талуудаас шалгаалан энэ зорилгод хүрэхдэд саад болж байна. Дэлхийн эдийн засагт хэд хэдэн нөлөө бүхий валют байгаа ч АНУ-ын долларыг орлох ганц ч хүчтэй валют одоогоор тодроогүй байна. Мөн ямар ч улс эсвэл төв банк шинэ “ноёрхогч валют” болж, бүх ачааллыг үүрэхийг тэр бүр хүсэхгүй байна. Тиймээс дэлхийн улс орнууд болон төв банкнууд валютын төвлөрлийг багасгаж, илүү тэнцвэртэй, тогтвортой олон улсын валютын тогтолцоог бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай болж байна.



МАРИ ФАВЕРО
Франц дахь Төв Азийн судалгааны
хүрээлэнгийн Захирал

"Монголын эзэнт гүрэн зөвхөн байлдан дагуулсан төдийгүй, харилцаа, худалдаа, соёлын солилцоогоор дамжуулан дэлхийд нолоолсон, түүхэн дэх анхны даяарчлагдсан гүрэн байв."

Монголын эзэнт гүрэн XIII–XIV зуунд Евроазийг хамарсан өргөн уудам нэгдмэл бүтэцтэй байж, зөвхөн байлдан дагуулалт бус худалдаа, соёлын солилцоог ч идэвхтэй хөгжүүлжээ. Энэхүү "Rax Mongolica" буюу "Монголын их амар амгалан" нь Евроазийн худалдаа, харилцаанд сууриссан даяаршлын хэлбэрийг бий болгож, улс орнуудын хооронд бараа болон мэдээлэл солилцох хурд болон худалдаачдын урсгалыг эрчимжүүлсэн. Монголчууд "Ям" (Өртөөг ингэж хэлэх нь бий) гэх шуудан-холбооны дэвшилтэт систем, татварын оновчтой зохицуулалт, нүүдэлчдийн уян хатан засаг захиргаа, хөрөнгийн дахин хуваарилалт зэрэг механизмыг бий болгон том гүрнийг үр ашигтай удирдаж чадсан байна. Эзэнт гүрэнд хүмүүсийг гарал угсаа бус ур чадвар, үүрэг, статусаар нь үнэлж, лам хуврагууд, гар урчуудыг татвараас чөлөөлөх зэрэг сонгомол бодлого хэрэгжүүлсэн. Монголын эзэнт гүрэн тухайн цаг үедээ даяар нэлөөтэй, ухаалаг бүтэцтэй, нэгдмэл систем бүхий гүрэн байсан нь түүний олон зууны турш оршин тогтоосон шалтгаан болсон юм.

ТҮВШИНТӨГС: НИЙЛҮҮЛЭЛТИЙН ШОК, ТАРИФЫН НӨЛӨӨ ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ТУЛГАРААД БАЙНА



■ ■ ■

**Зочны ярилцлага буландаа
“Дэлхийн эдийн засаг:
Мөнгөний бодлогын
үр нөлөө” Олон Улсын
өндөр түвшний II хурлын
“Тариф ба нийлуулэлтийн
шокийн үеийн мөнгөний
бодлого” хуралдааныг
удирдсан Монгол Улсын Их
Сургуулийн, Эдийн засгийн
тэнхимийн профессор
Б.Түвшинтөгстэй эдийн
засгийн шокийн үед
хэрэгжүүлэх төсөв мөнгөний
бодлогын талаар ярилцлаа**

**ТАРИФ, ХУДАЛДААНЫ
АСУУДАЛД УЛС ОРНУУД
ЯМАР ХАНДЛАГАТАЙ
БАЙНА ВЭ, МӨНГӨНИЙ
БОДЛОГО НЬ
НИЙЛҮҮЛЭЛТИЙН БОЛОН
ХУДАЛДААНЫ АСУУДАЛД
ХЭРХЭН ЧИГЛЭЖ БАЙНА
ВЭ?**

Миний удирдсан хурлаар нийлуулэлтийн шокод оруулж байгаа нөлөө төв банк мөнгөний бодлого талаас ямар хариу үйлдэл хийх талаар ярилцсан. Хэлэлцүүлгийн эхэнд бид нийлуулэлтийн шок гэж юу болох талаар нэгдсэн ойлголттой байх хэрэгтэй байв. Өөрөөр хэлбэл, бизнесийн үйл ажиллагаа явуулах, үйлдвэрлэл үйлчилгээ бий болгоход гарч байгаа

зардлын шок гэж ойлгож байгаа юм. Тухайлбал, Монголбанк болон төрийн бодлогоос үл хамаарах байдлаар үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зардал нь өсөөд ирвэл нийлуулэлтийн шок болж байна гэсэн үг. Жишээлбэл, янз бүрийн инфляцын хүлээлтүүд байж болдог. Өөрөөр хэлбэл, эдийн засагт юмны үнэ өснө гэсэн хүлээлт давамгайлвал юуны түрүүнд хөдөлмөрийн гэрээ хийх, худалдан авалт хийх үнийг өсгөчихдөг. Тэгэхээр үйлдвэрлэл үйлчилгээ явуулах зардал өсдөг учраас бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэж, харин үйлдвэрлэл үйлчилгээний хэмжээ багасдаг. Өндөр зардлаас болоод зарим нь бүр зогсоход хүрэх сөрөг нөлөөтэй. Тэгэхээр үйлдвэрлэл нь багасаад үнэ өсөхөөр инфляц

ч, мөн ажилгүйдэл ч өсдөг. Үүнийг бид нийлүүлэлтийн шок гэж тайлбарлаж байгаа юм. Энэ тохиолдолд төв банк мөнгөний бодлогоор дамжуулан нөлөөлж чадах уу, чадвал ямар хэмжээгээр нөлөөлж чадах вэ, гэвч эсхүл огт чадахгүй ч байж болно. Бид энэ талаар түлхүү хэлэлцлээ. Зарим улс орнууд ялангуяа, манайх шиг улс нийлүүлэлтийн шоконд өртөмтгий. Тухайлбал, нефтийн бүтээгдэхүүнүүдээрээ нэг орноос хамааралтай. Нөгөөтээгүүр газар зүйн байрлалын хувьд гол худалдаа хийгч улс орнуудаас маш хол, далайд гарц байхгүй, хүн ам цөөн, хөдөлмөрийн хүч нь хязгаарлагдмал зэрэг хүчин зүйлс нь бизнесийн зардлыг өндөр болгодог. Дээр нь янз бүрийн шок орж ирвэл зардлыг улам л өсгөнө. Хөгжсөн орнуудын хувьд асуудал харьцангуй бага. Яагаад гэвэл, тэнд боловсролтой бэлтгэгдсэн боловсон хүчний бааз суурь сайн, хөдөлмөрийн нийлүүлэлт нь ч хангалттай. Зөвхөн цалингаас хамаардаг гэсэн үг. Мөн далайд гарцтай, зардал багатай үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг. Тийм учраас шок орж ирэхэд нэг салбартаа шингээгээд том эдийн засагтаа нөлөө үзүүлэхгүй байх боломж ихтэй. Иймд мөнгөний бодлого нь тэдгээр улс орнуудад өөр манайхаас өөрөөр томьёологдоно.

**МАНАЙ УЛС
БОДЛОГЫНХОО
ХҮҮГ ХАТУУ ХЭВЭЭР
ХАДГАЛСААР БАЙНА.
ХӨГЖИХ БАЙГАА
КАЗАКСТАН Ч ГЭДЭГ ЮМ
УУ МӨН АДИЛ БОДЛОГО
БАРЬЖ БАЙНА. ХАРИН
НӨГӨӨ ТАЛААС БАРУУНЫ
УЛС ОРНУУД ИЛҮҮ
СУЛРУУЛАХ ХАНДЛАГА
РУУГАА ЧИГЛЭЭД
ЭХЭЛЛЭЭ. ЭНДЭЭС
ХАРАХАД ӨМНӨ НЬ
ТОМ ЭДИЙН ЗАСГУУДЫГ
БУСАД НЬ ДАГАЖ
ХӨДӨЛДӨГ БАЙСАН БОЛ
ЭНЭ УДАА ЭСРЭГЭРЭЭ
БОЛЖ БАЙНА ШҮҮ
ДЭЭ. ИНГЭЖ ЯЛГААТАЙ
БАЙДАЛ ГАРЧ БАЙГАА НЬ
ЯМАР НӨХЦӨЛД ХҮРГЭХ
БОЛ?**

Чухал асуулт байна. Өнөөгийн байдлаар нийлүүлэлтийн шок, тариfyн нөлөө глобал эдийн засагт тулгараад байна. Та бүхэн мэдэж байгаа байх. Улс орнууд тарифаа өсгөж байна. Ялангуяа, АНУ-ын тариfyн өсөлтийн улмаас улс орнууд өөрийн тарифаа эргэж харах шаардлагатай болоод байна. Энэ үйл явц нь манайх шиг улсад дам нөлөө үзүүлнэ. Ойлгомжтой шүү дээ, импортын бараа бүтээгдэхүүнүүд дээр тод илэрнэ. Жишээлбэл, энэ шийдвэрүүдийн улмаас улс орнууд Америк руу илүү үнэтэй зараг ёстай болно, Америкаас авах орц нь мөн үнэтэй болно. Хятадын орц мөн

үнэтэй болохоор манай авах үнэ өсөх учраас үүнийг дам нөлөө гэж байгаа юм. Тэгэхээр тариfyн болоод нийлүүлэлтийн зардлын шокууд нийлүүлэлтдээ нөлөөлж, өөрөөр хэлбэл бид нарын үйл ажиллагааг илүү зардалтай болгож, үйлдвэрлэл багасах, эдийн засаг хямрах, инфляц өсөх гэх мэт нөхцөл байдал руу түлхэж байна. Хөгжсөн болон хөгжих байгаа манайх шиг орны нөхцөл байдал хоорондоо ялгаатай байна гэдэг нь ийм л учиртай юм.

**ТЭГЭХЭЭР ТӨВ БАНКНААС
МӨНГӨНИЙ БОДЛОГОО
ЦААШИД ЗӨӨЛЛӨХ,
ШОКИЙГ БУУРУУЛАХ
ЧИГЛЭЛД ЗОРЬЖ БАЙГАА
БАЙХ. ЭНЭ ХУРЛЫН
ЗОРИЛГО Ч МӨН ҮҮНД
ЧИГЛЭСЭН АСУУДЛУУДЫГ
ЯРИЛЦАХАД ЗОРЬСОН
ГЭЖ ОЙЛГОЖ БОЛОХ УУ?**

Гаднаас сөрөг шокийн нөлөөлөөгөөр зардал өсөнгүүт төв банк, мөнгөний бодлого маш хүнд байдалд ордог. Мөнгөний бодлого бол нийт эрэлтийг зохицуулдаг бодлого. Мөнгөний тэлэх бодлого явуулбал мөнгөний нийлүүлэлтийг өсгөж нийт худалдан авалтыг нэмэгдүүлдэг. Эсвэл хатуу бодлого явуулж, нийт эрэлтийг бууруулдаг (худалдан авалтыг бууруулдаг). Энэ тохиолдолд тэгвэл яах вэ, мөнгөний бодлого тэлэх үү, сөрөх үү? гэдэг сонголт дээр ирнэ. Жишээлбэл, тэлчихлээ гэж

бодоход, бараа бүтээгдэхүүний үнэ улам өснө. Гэхдээ үйлдвэрлэл өснө, ажилгүйдэл багасна гэсэн үг. Эсрэгээрээ хатууруулах юм бол үнэ буурч инфляц өсөхгүй ч үйлдвэрлэл улам хүчтэй унаж, ажилгүйдэл өснө. Тийм учраас төв банк нийлүүлэлт, зардлын хүнд шокийн үед иймэрхүү байдлаар хүнд сонголтын өмнө ирдэг. Одоо бол яг ийм сонголтой тулчихсан байгаа.

**ТӨМ ЭДИЙН ЗАСАГТАЙ
УЛС ОРНУУД БОДЛОГЫН
ШИЙДВЭРЭЭ НЭГЭНТ
ГАРГААД ЯВЖ БАЙНА.
ХАРИН ХӨГЖИЖ
БҮЙ УЛС ОРНУУДЫН
ХУВЬД ЦААШДЫН ЧИГ
ХАНДЛАГА ЯМАР БАЙХ
БОЛ. ЯЛАНГУЯА, ЭНЭ
ХУРЛААС ЯМАР ҮР ДҮН
ХҮЛЭЭГДЭЖ БАЙНА ВЭ?**

зуур өсчихөөд тэндээ тогтчихвол мөнгөний бодлогоо аядуухан тогтвортой барьж байгаад байдлыг даваад гарах сонголт бий. Хэрэв зээ энэ нь ужгираад, зардал нь илүү их өсөөд байх юм бол инфляц төв банкны зорилтоос илүү өндөр давах тохиолдолд төв банкны хариу үйлдэл нь хатуу бодлого барих ёстой болно.

Ярилцсанд баярлалаа.

Хурлаар яригдсан гол асуудал бол мөнгөний бодлогыг яаж томьёолох ёстой юм бэ гэдэг гол асуудал. Монгол бол инфляцыг зорилтод түвшинд хангана гэж зарладаг улс. Үүнээс өөр зорилт байхгүй. Тэгэхээр орчны ийм нөхцөл байдлын үед инфляциад зоривол мөнгөний хэтэрхий хатуу бодлого баримталж, бодлогын хүүг өсгөнө. Тэгвэл өөр арай зөөлөн бодлого явуулах, эсхүл хүлээх арга байна уу? гэдэг талаар ярилцацаасан гэсэн үг. Тэр нь юунаас хамаарах вэ гэвэл нийлүүлэлт, зардлын сөрөг шок нь хэр удаан үргэлжлэх вэ гэдгээс хамаарна. Хэрвээ түр



Монгол Улсад үндэсний мөнгөн тэмдэгт “Төгрөг”-ийг гүйлгээнд гаргасны 100 жилийн ойг тохиолдуулан Монголбанкнаас “Нэг төгрөг” дурсгалын алт болон мөнгөн зоос худалдаанд гаргалаа.

Үйлдвэрлэсэн технологи:
Smartminting ultra high relief


Сорьц: Алтан зоос 1 унц

Мөнгөн зоос 999.9

Хэмжээ: 33 мм

Жин: 31.1 гр





МИТАЛИ ДАС

ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САНГИЙН ТӨСВИЙН БОДЛОГО
ХАРИУЦСАН ЗӨВЛӨХ

KОВИД-19 цар тахал дэлхийн эдийн засагт урьд өмнө тохиолдоогүй цохилт болсон бөгөөд 2020 онд дэлхийн бараг бүх улсад үйлдвэрлэл огцом унасан байна. Гэхдээ цар тахлаас хойших үйл явдал хоёр өөр түүхийг өгүүлж байна. Хөгжингүй орнууд төсвийн болон мөнгөний бодлогын хүчтэй арга хэмжээнүүд авсны үр дүнд хурдан сэргэсэн бөгөөд 2024 он гэхэд ихэнх нь цар тахлын өмнөх өсөлтийн замдаа эргэн орсон бол зарим нь бүр давсан үзүүлэлттэй гарсан. Харин хурдацтай хөгжиж буй орнуудад үйлдвэрлэл эсрэгээрээ хямралын өмнөх төсөөллөөс бага хэвээр үлджээ.

Энэ нь яагаад чухал вэ гэвэл хурдацтай хөгжиж буй зах зээлийн хувьд аливаа эдийн засгийн шок нь зөвхөн түр зуурын уналт биш, харин өсөлтийн замыг тэр чигт нь доош татах цохилт болдгийг энэ үйл явц харуулж байна. Энэ нь Марк Агуиар болон Гита Гопинат нарын 2007 онд "Journal of Political Economy" сэтгүүлд нийтлүүлсэн "Хурдацтай хөгжиж буй зах зээлийн бизнес мөчлөг: Мөчлөг чиг хандлага болохуй" ("Emerging Market Business Cycles: The Cycle is the Trend") судалгааны нийтлэлийн үндсэн гол санааг сануулж байна. Эдийн засгийн уналтын дараа хурдацтай хөгжиж буй зах зээлийн үйлдвэрлэл өмнөх чиг хандлагадаа эргэн очдоггүй, харин түүнээс доогуур шинэ зам руу шилждэг.

ОУВС-аас эрхлэн гаргадаг "Дэлхийн эдийн засгийн төлөв" товхимлын мэдээллийн сангаас цар тахлын өмнөх (2020 оны 1-р сар) болон 2022 оны 1-р сард гаргасан бодит ДНБ-ий төсөөлүүдийг харьцуулж үзэхэд 2020 онд хөгжингүй болон хурдацтай хөгжиж буй зах зээлүүдийн бодит ДНБ 2019 онтой харьцуулахад ижил буюу 6.5 нэгж хувиар буурсан байв. Гэтэл бараг бүх хөгжингүй орны үйлдвэрлэлийг 2024 он гэхэд чиг хандлагадаа эргэн очно гэсэн төсөөлөл байсан бол, хурдацтай хөгжиж буй эдийн засгтай ихэнх орнууд, түүний дотор БНХАУ, Энэтхэг болон судалгаанд хамрагдсан бусад 40 орнуудын 25-д нь үйлдвэрлэл цар тахлын өмнөх чиг хандлагад хүрч чадаагүй байна.

Ийм алдагдал нь зөвхөн ДНБ-ээр хязгаарлагдаагүй юм. Хурдацтай хөгжиж буй зах зээлд хэрэглээ үйлдвэрлэлээс ч илүү унасан нь санаанд оромгүй үр дүн байв. Учир нь хямралын үед айл өрхүүд хэрэглээгээ ихэвчлэн тогтвортой байлгахыг эрмэлзэдэг болохоор энэ нь ердийн хүлэлттэй зөрчилдэж байлаа. Хөрөнгө оруулалтын хувьд ч ялгаатай байв. Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрүүдийн ачаар хөрөнгө оруулалт хөгжингүй орнуудад эрчимтэй сэргэсэн бол, хурдацтай хөгжиж буй орнуудын хөрөнгө оруулалт уналтад орсон хэвээр байв. Энэ ялгаа нь ажил эрхлэлт, хөдөлмөрийн бүтээмж, нийт

хүчин зүйлийн бүтээмж зэрэг макро үзүүлэлтүүдэд ч харагдаж байна.

Ийм үр дүн гарахад бодлогын нөлөө чухал байсан. Хөгжингүй орнууд өргөн цар хүрээтэй төсвийн шилжилт хийж, тэлж буй бодлогын арга хэмжээг өндөр дүнгээр авч хэрэгжүүлэн, вакцинд шуурхай хамруулж эхэлсэн зэргээр хариу арга хэмжээг оновчтой авсан нь өрхийн амьжиргааг дэмжин, хүлээлтийг тогтворжуулж, хөрөнгө оруулалтыг дэмжсэн. Харин хурдацтай хөгжиж буй зах зээл бүхий орнуудад боломж хязгаарлагдмал байлаа. Эдгээр улсууд өрийн түвшин өндөр, санхүүгийн зах зээлээс эх үүсвэр босгох боломж хязгаарлагдмал зэрэг асуудлуутай нүүр тулгарсан бөгөөд инфляц, валютын ханшийн уналтад санаа зовнисон зэрэг шалтгаанаар бодлогын дэмжлэг бага байгаад зогсохгүй ихэнхдээ удаашралтай байв. Тогтворжуулах хэрэгсэл байсан ч, тэдгээрийг ашиглан хариу арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байлаа. Үүнээс гадна бүтцийн хүчин зүйлс мөн нөлөөлсөн. Тухайлбал, хөгжингүй орнуудад интернэтийн сүлжээ илүү сайн хөгжсөн учраас зайнаас ажиллах боломж илүү, эрүүл мэндийн хямралыг зохицуулахад эмнэлгийн тоног төхөөрөмж, хангамж сайтай байсан нь давуу тал болсон.

Түүнчлэн эдийн засгийн томоохон шокуудыг даван туулахад хүчирхэг институц чухал болох нь мөн харагдлаа. Сайн зохион байгуулалттай, ил тод, уян хатан институциуд түр зуурын саатал эсвэл байнгын алдагдал үүсэх ялгааг тодорхойлох гол хүчин зүйл болсон юм. Үүнд зөвхөн эрүүл мэндийн систем болон дижитал дэд бүтэц төдийгүй, хямралын үед хариу арга хэмжээг шуурхай авах чадамжтай институциуд ч багтана. Жишээ нь, байгалийн нөөц ихтэй улс орнуудын хувьд "Үндэсний баялгийн сан" нь эдийн засгийн чухал тогтворжуулагч болж, төсвийн орлого тасарсан үед мөчлөг сөрсөн төсвийн зардлыг өсөлтийн үед хуримтлуулсан хуримтлалаар санхүүжүүлэх боломж олгосон. Цар тахлын дараа, төсвийн хүрээний шинэ үеийн тогтолцоо бий болж байна. Энэ нь хуримтлалын сангийн дүрмийг шокийн үед төсвийн зарцуулалт хийх нарийн тодорхойлсон механизмуудтай хослуулахад чиглэж байна.

Хурдацтай хөгжиж буй зах зээлийн хувьд эдийн засгийн уналт ихэнхдээ түр зуурын бус, харин урт хугацааны сорви үлдээдэг гэсэн нутагшсан хэв шинжийг Ковид-19 цар тахал дахин батлав. Хөгжингүй орнуудын хувьд мөчлөг нь зүгээр л түр зогсолт байсан бол, хурдацтай хөгжиж буй зах зээлд тэрхүү мөчлөг нь чиг хандлага болж үлдсэн. Цаашид энэхүү ялгаатай байдлыг арилгахын тулд эдийн засгийн эрсдэл даах чадварыг бэхжүүлэх шаардлагатай бөгөөд ингэснээр ирээдүйд шокийн улмаас эдийн засгийн өсөлтийн зам тэр чигтээ өөрчлөгдөхөөс сэргийлнэ. Үүний тулд макро эдийн засгийн тогтолцоог бэхжүүлж, хямралын эсрэг хариу арга хэмжээ авах чадамжийг сайжруулан, урт хугацааны өсөлтийн тулгуур болох эрүүл мэнд, боловсрол, дэд бүтцэд хөрөнгө оруулах шаардлагатай байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

.... дугаар сарын статистик үзүүлэлт (ССГ)

ИНФЛЯЦЫН ТҮВШИН

Бодлогын хүүг 2025 оны 3 дугаар сард 2.0 нэгж хувиар нэмэгдүүлж **12.0** хувьд хүргэв.



Эх сурвалж: Монголбанк

ХУНСНИЙ УНИЙН ЖИЛИЙН
ӨӨРЧЛӨЛТ
УЛААНБААТАР
ХОТ




Сахар, жимсний
чанамал, чихэр,
шоколад
12.0%



Талх, гурил,
будаа
3.3%

2025 оны 6 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд жилийн
инфляц 8.2 хувьтай гарав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо



Төрөл бүрийн
өөх, тос
10.8%



Мах, махан
бүтээгдэхүүн
9.2%



Хунсний
ногоо
3.2%



Сүү, сүүн
бүтээгдэхүүн
2.1%


1

M2 МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ


M2 мөнгөний нийлүүлэлт 2025 оны 6 дугаар сард 43.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.7% -иар өсөв.

M2 мөнгөний жилийн өсөлтийн **18.0** нэгж хувийг ДЦА, **-14.3** нэгж хувийг ГЦА бүрдүүлж байна.

M2-ийн эсилүүлэлт, эх үүсвэр талаас



M2-ийн эсилүүлэлт, байршиулалт талаас




Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН

ЗЭЭЛ

2025 оны 6 дугаар сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос **27.0%-иар өсөж 42.2 их наяд төгрөгт** хүрэв.

Зээлийн жилийн өсвөлт



2025 оны 6 дугаар сарын байдлаар **чанаргүй зээл 4.9%**-тай байна.

Зээлийн үлдэгдэл

Зээлийн үлдэгдэл /Тэрбум ₮/	2021	2022	2023	2024	2025.06	Жин	Өөрчлөлт 2025.06/2024.06
Үүл уурхай	1,851	1,173	1,416	2,494	2,449	5.8%	28.6%
Боловсруулах	1,666	1,528	2,012	2,225	2,730	6.5%	19.3%
Худалдаа	4,121	4,752	5,438	6,464	8,105	19.2%	31.3%
Барилга	1,637	1,779	1,843	2,292	2,914	6.9%	36.9%
Ипотек	2,653	3,055	3,571	5,324	5,931	14.0%	25.7%
Хэрэглээ болон хадгаламж барьцаалсан	5,313	5,954	8,412	11,398	12,405	29.4%	19.6%
Бусад	3,426	3,767	4,453	6,585	7,690	18.2%	35.5%
Нийт	20,667	22,008	27,144	36,781	42,224	100.0%	27.0%
Чанарын ангиллаар нийт зээл эзлэх жин							
Анхаарал хандуулах	4.5%	5.1%	4.7%	3.5%	4.2%		
Чанаргүй	10.0%	9.2%	7.5%	5.1%	4.9%		
Зээлийн долларжилт	7.3%	5.8%	6.1%	6.2%	6.2%		


Эх сурвалж: Монголбанк

БЖДУ

ЗЭЭЛ

БЖДУ-ийн зээл 2025 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс **28.2%-аар өсөж 9.6 их наяд төгрөгт** хүрэв. Тухайн сард **1,376.7** тэрбум төгрөгийн зээл олгож, **827.8** тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн байна.

БЖДУ эрхлэгчдэд олгосон зээл



Худалдаа, барилга, боловсруулах, ХАА-н салбарт дийлэнх зээл олгогджээ. Нийт БЖДУ зээлийн үлдэгдлийн **6.6%** нь чанаргүй, **2.5%** нь анхаарал хандуулах зээл байна,

БЖДУ эрхлэгчдийн зээл

Зээлийн үлдэгдэл /Тэрбум ₮/	2020	2021	2022	2023	2024	2025.06	Жин	Өөрчлөлт 2025.06/2024.06
Хөдөө аж ахуй	162	228	246	324	541	725	7.6%	88.3%
Боловсруулах	449	621	553	656	643	762	7.9%	14.5%
Худалдаа	956	2,201	2,054	2,548	3,315	4,160	43.4%	34.5%
Барилга	410	608	661	696	789	968	10.1%	16.1%
Үйлчилгээ	189	321	183	278	341	395	4.1%	24.5%
Бусад	1,403	1,612	1,657	1,817	2,313	2,580	26.9%	18.0%
Нийт	3,569	5,592	5,354	6,321	7,940	9,590	100.0%	28.2%
Чанарын ангиллаар нийт зээл эзлэх жин								
Анхаарал хандуулах	11.6%	3.8%	5.9%	4.1%	2.3%	2.5%		
Чанаргүй	18.4%	10.5%	11.9%	10.5%	7.8%	6.6%		
Нийт зээлд БЖДУ зээлийн эзлэх жин	21.0%	27.1%	24.3%	23.3%	21.9%	22.7%		


Эх сурвалж: Монголбанк

ИПОТЕКИЙН

ЗЭЭЛ

2025 оны 6 дугаар сард **304.7** тэрбум төгрөгийн ипотекийн зээл олгож, нийт зээлийн үлдэгдэл **10.4 их наяд төгрөгт** хүрэв.

Тухайн сард олгосон ипотекийн зээл




Тухайн сард шинээр олгосон ипотекийн зээлийн жигнэсэн дундаж хүг **13.3%** байна.

Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо




Эх сурвалж: Монголбанк


БАНКУУДЫН

ХҮҮ

Банкуудын зээл, хадгаламжийн хүний зөвүү



Шинээр олгосон төгрөгийн зээлийн хүний тархалт



Эх сурвалж: Монголбанк


ГАДААД

ХУДАЛДАА

БАРААНЫ ЭКСПОРТ

2025.06

6,229 сая \$



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар

ГАДААД

ХУДАЛДАА

БАРААНЫ ИМПОРТ

2025.06

5,528 сая \$




Эх сурвалж: Гаалийн Ерөнхий газар


ТӨЛБӨРИЙН

ТЭНЦЭЛ

Үйлчилгээний экспорт, сая \$



Үйлчилгээний импорт, сая \$




ТЭЭВЭР 363 сая \$



АЯЛАЛ 281 сая \$



БУСАД 195 сая \$



ТЭЭВЭР 728 сая \$



АЯЛАЛ 844 сая \$



БУСАД 748 сая \$



Эх сурвалж: Гаалийн өргөхийн газар, Монголбанк 9


ТӨЛБӨРИЙН

ТЭНЦЭЛ

Үргслал болон хөрөнгийн дансны тэнцэл, сая \$



Санхүүгийн дансны тэнцэл, сая \$



Төлбөрийн тэнцэл
\$-462 сая



Бараа
\$-462 сая



Үйлчилгээ
-\$1,481 сая

Аяндагч орлого
\$-1,206 сая



Хоёрдогч орлого
\$172 сая

Хөрөнгийн данс
\$51 сая



Санхүүгийн дансны бүтэц

Шууд хөрөнгө оруулалт



\$1,013 сая

Санхүүгийн үүсмэл хэрэгслийд



\$-15 сая

Багцын хөрөнгө оруулалт



\$77 сая

Бусад хөрөнгө оруулалт



\$567 сая

Эх сурвалж: Монголбанк

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БҮЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

/2025 оны 8-р сарын 5-ны өдрийн байдлаар/

ТОВЧ АГУУЛГА

АНУ-ын зүгээс ихэнх улс орнуудад ноогдуулах тарифын түвшинг шинэчлэн тогтоов. Харин БНХАУ-тай өрнүүлж буй худалдааны хэлэлцээр үргэлжилж байна.

Тарифын шийдвэрүүдээс хамаарч алт, зэсийн үнэ нэмэгдэх хандлагатай байна.

Төмрийн хүдэр, нүүрсний үнэ 7-р сард өсөх хандлагатай байсан бол сүүлийн өдрүүдэд эргэн буурч эхэллээ. Харин газрын тосны үнэ хэлбэлзэн хэвээр байна.

ТРАМПЫН ТАРИФЫН БОДЛОГО ~ ЦУВРАЛ 5

АНУ-ын зүгээс улс орнуудад ногдуулсан өндөр тариф 7-р сарын 8-ны өдрөөс хэрэгжиж эхлэхээр байсан ч үүнээс 1 хоногийн өмнө хугацааг дахин сунгаж 8-р сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулах тушаалд Дональд Трамп гарын үсэг зураад байв. Улмаар улс орнууд руу албан захидал хүргүүлж, тухайн улсын тарифыг хэдэн хувиар тогтоох хүсэлтэй байгаагаа илрэхийлсэн. Ихэнх улсуудын хувьд 4-р сард танилцуулсантай ижил хувийн тариф тогтоохоор төлөвлөж буйг албан захидалд тусгажээ. Үүний хариуд зарим улсууд тарифын хувийг буулгах хэлэлцээрээ үргэлжлүүлсэн бол тарифын хувийг хүлээн зөвшөөрөх улсууд ч цөөнгүй байв.

Эдгээр үйл явдлын дараа буюу 7-р сарын 31-ний өдөр Дональд Трамп худалдааны түнш 67 орны хувьд тарифын хувь хэмжээг шинэчлэн тогтоосноо танилцуулав. Эдгээр улсуудын хувьд импортын тариф 10 хувиас 41 хувийн хооронд байх бөгөөд 8-р сарын 7-ны өдрөөс хэрэгжиж эхлэхээр тусгажээ. Хамгийн өндөр буюу 41 хувийн тарифыг Сири улсад тогтоосон бол өмнө нь өндөр тариф тогтоолгоод байсан ихэнх улсууд хэлэлцээр хийж тарифын хэмжээг 4-р сард танилцуулсан хэмжээнээс бууруулж чаджээ. Үүнээс дурдвал:

- Лесото 50 хувиас 15 хувь;
- Камбож 49 хувиас 19 хувь;
- Вьетнам 46 хувиас 20 хувь;
- Тайланд 36 хувиас 19 хувь;

Цөөн хэдэн улсын хувьд тарифын хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр гаргасныг мөн дурдвал:

- Бразил улсад анх 10 хувийн тариф ногдуулахаар зарлаад байсан ч 7-р сарын 31-нд шийдвэрээ өөрчилж 40 нэгж хувийн нэмэлт тариф ногдуулах тушаал гаргалаа. Энэхүү шийдвэр нь Бразилын өмнөх ерөнхийлөгч Жэир Болсонарод үүсгээд буй хэргийн хариу болохыг онцлов. Ингэснээр тус улс одоогоор хамгийн өндөр буюу 50 хувийн тарифтай байхаар боллоо.
- Мексикт 30 хувийн, Канадад 35 хувийн тариф тогтоохоор шийдвэрлэв. Ийнхүү өсгөх болсон талаараа анх 7-р сарын 11-ний өдөр явуулсан захиандaa дурдсан юм.

о Канад улсыг тарифын эсрэг хариу арга хэмжээ авсан гэж буруутгахаас гадна АНУ руу Канадаас фентанил орж ирсээр байгааг онцлов.

о Гэхдээ 2020 оны 7-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн USMCA1 худалдааны хэлэлцээрийн хүрээнд Канад, Мексик улсуудын ихэнх бараа тарифгүй байх тул энэхүү өндөр тарифт хамаарах бараа бүтээгдэхүүн цөөхөн байхаар байна.

УЛС ОРНУУДТАЙ ХИЙЖ БУЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ЯВЦЫН ТАЛААР ТУС БҮРД НЬ АВЧ ҮЗЬЕ.



• БНХАУ

о 7-р сарын 28-нд Шведийн Стокholm хотод АНУ-ын Сангийн сайд Скот Бессент, БНХАУ-ын Ерөнхий сайдын орлогч Хэ Лилен тэргүүтэй өндөр хэмжээний уулзалт болов. Энэхүү уулзалтаар 8-р сарын 12-нд дуусах тус улсад ногдуулах өндөр тарифыг хойшлуулсан хугацааг цаашид дахин 90 хоногоор сунгахаар урьдчилсан тохиролцсон байна. Одоо үүнийг Ерөнхийлөгч Трамп батлах л үлдээд байна.

§ Одоогоор 2 тал урт хугацааны хэлэлцээрт хүрээгүй байна. Тиймээс хоёр тал тарифын хугацааг хойшлуулж хэлэлцээрээ үргэлжлүүлэх сонирхолтой байна.



• ЕВРОПЫН ХОЛБОО (ЕХ)

о 7-р сарын 27-ны өдөр хоёр тал худалдааны тохиролцоонд хүрсэн талаараа мэдэгдэв. Ерөнхий зүйлсээ тохирсон ч нарийвчилсан заалтууд бүрэн тодорхой болоогүй байна. Гэрээнд дараах зүйлс багтсан талаар эх сурвалжууд мэдээлэв.

§ АНУ-ын талаас ЕХ-ны улсуудын авто машин болон бусад бүх бараанд 15 хувийн татвар ногдуулна. Үүнд, 50 хувийн татвар ногдуулж буй ган, хөнгөн цагаан хамаарахгүй.

§ ЕХ ойрын 3 жилд АНУ-аас 750 тэрбум ам.долларын эрчим хүч худалдан авна. Энэ нь ЕХ-ны улсуудын зах зээл дэх ОХУ-ын газрын тос, газны нөлөөг багасгах зорилготой юм.

§ АНУ-аас 40 тэрбум ам.долларын AI чипийг ЕХ худалдан авна.

§ ЕХ-ны компаниуд АНУ-д аль хэдийн 2.4 их наяд еврогийн хөрөнгө оруулалт хийхээд байгаа бөгөөд цаашид ч хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна. Тодруулбал, хэлэлцээрийн үеэр 2029 он хүртэл багадаа 550 тэрбум еврогийн (600 сая ам.доллар) нэмэлт хөрөнгө оруулалт хийхээр тохиром.

§ Нисэх онгоц, тэдгээрийн эд анги, зарим химийн бодис, хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүн зэрэг стратегийн бүтээгдэхүүнд харилцан татваргүй байхаар тохиром.

§ Одоо энэхүү худалдааны гэрээг ЕХ-ны нийт 27 гишүүн орон батлах шаардлагатай юм.

о 8-р сарын 4-нд ЕХ АНУ-ын тарифын эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээгээ б сараар хойшлуулж буйгаа мэдэгдлээ. Энэ нь АНУ-тай худалдааны хэлэлцээрээ бүрэн тохиорох боломж олгох аж.



• ЯПОН

о 7-р сарын 23-нд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Япон улстай худалдааны хэлэлцээр амжилттай болсон талаар мэдэгдлээ. Энэхүү гэрээний заалтууд бүрэн тодорхой болоогүй байгаа ч дараах ерөнхий зүйлс багтсан аж.

§ АНУ нь Японоос ирж буй импортын бүх бараа бүтээгдэхүүнээс 15 хувийн татвар авна.

§ Япон улс АНУ-д 550 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийх бөгөөд тус хөрөнгө оруулалтаас олох ашгийн 90 хувийг АНУ авна.



• БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС (БНСУ)

о 7-р сарын 31-ний өдөр Дональд Трамп БНСУ-тай худалдааны тохиролцоонд хүрсэн талаараа мэдэгдэв. Энэхүү гэрээнд дараах заалтууд багтсан байна.

§ АНУ-аас БНСУ-ын бараа бүтээгдэхүүнд 15 хувийн тариф ногдуулна.

§ БНСУ АНУ-аас 100 тэрбум ам.долларын өртөг бүхий шингэрүүлсэн байгалийн хий болон бусад эрчим хүчний бүтээгдэхүүн худалдаж авна.



• МАЛАЙЗ

о 8-р сарын 4-нд хоёр тал худалдааны тохиролцоонд хүрснээ зарлав. Энэхүү гэрээнд дараах зүйлс багтсан ажээ.

§ АНУ-ын тал Малайзын бараа бүтээгдэхүүнд 19 хувийн тариф ногдуулна.

§ Малайз улс АНУ-аас худалдан авдаг бараа бүтээгдэхүүний 98.4 хувийн тарифыг бууруулах эсвэл татваргүй болгоно. Түүнчлэн, тарифын бус саадыг бууруулах амлалт өглөө.

§ Ирэх 5 жилийн хугацаанд Малайз улс АНУ-аас 150 тэрбум ам.долларын технологийн бүтээгдэхүүн худалдан авна.

§ Малайз улс жил бүр 3.4 тэрбум ам.долларын үнэ бүхий шингэрүүлсэн байгалийн хий АНУ-аас худалдан авна.

III. ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

Дараах хүснэгтэд манай улсын экспортын гол түүхий эдүүдийн үнэ хэрхэн өөрчлөгджэх байгааг 2025 оны 8-р сарын 4-ний өдрийн байдлаар харуулж, өөрчлөлтийн гол шалтгааныг тайлбарлалаа.

Хүснэгт 1. Экспортын гол нэрийн түүхий эдийн үнийн өөрчлөлт

Түүхий эдийн терөл	Үнэ	Өөрчлөлт, %			
		7 хоног	Cap	оны эхнээс	жил
	9687 \$/тн	-0.8	-1.8	+10.5	+9.0
Тарифтай холбоотой гэнэтийн шийдвэрүүд, үйл явдлуудын нөлөөгөөр зэсийн үнэ хэлбэлзсэн хэвээр байна. Эдгээрийг дурдвал:					
Тарифын шийдвэрүүд					
<ul style="list-style-type: none"> Дональд Трамп 7-р сарын 9-нд хийсэн мэдэгдэлдээ 8-р сарын 1-ээс эхлэн зэсийн импортод 50 хувийн тариф ногдуулахаар болсноо зарлав. о АНУ-ын хувьд жилд 1.6 сая тонн цэвэршүүлсэн зэс хэрэглэдэг ч 1.1 сая тонныг л үйлдвэрлэдэг юм. о Чили улс АНУ-ын цэвэршүүлсэн зэсийн импортын 60 хувийг дангаар бүрдүүлдэг байна. 7 сарын 30-нд Дональд Трамп энэхүү 50 хувийн өндөр тарифт цэвэршүүлсэн зэс хамаарахгүй гэж мэдэгдэв. Өөрөөр хэлбэл энэхүү 50 хувийн тариф нь хагас боловсруулсан зэс бүтээгдэхүүн рүү чиглэж байгаа аж. 					
Зэс					
Эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэргүй байдал					
<ul style="list-style-type: none"> Энэ оны 5-р сард болсон газар хөдлөлт, түүнээс үүдсэн үерээс шалтгаалж Ардчилсан Конго улсын Kamoa-Kakula уурхайн үйл ажиллагаа доголдсон ч 6-р сараас эргэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн юм. Гэвч уурхайн менежментийн багийн мэдээллээс үзэхэд тус уурхайн олборлолт өмнө нь төлөвлөж байснаас бага байгаа бөгөөд засварын ажил 2026 оны дундуур дуусах хүлээлттэй байна. Энэ оны 7-р сарын 31-нд болсон 4.2 магнитудын газар хөдлөлтийн улмаас дэлхийн хамгийн том гүний уурхай болох Чилийн El Teniente-д осол гарч үйл ажиллагаа зогссон нь зэсийн нийлүүлэлт тасалдаад хүргээд байна. Энэхүү уурхай нь Чили улсын төрийн өмчит Codelco компанийн нийт зэс олборлолтын 25 орчим хувийг дангаар бүрдүүлдэг буюу жилдээ 400 мянган тонн орчим цэвэршүүлсэн зэс үйлдвэрлэдэг² уурхай юм. Ийнхүү зэсийн нийлүүлэлт тасалдаж байгаа үед эрэлт харьцангуй тогтвортой байгаа нь үнийн хэлбэлзэлд том нөлөө үзүүлж байна. 					

² БНХАУ-ын цэвэршүүлсэн зэсийн импортын 1 сар гаруйн хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээ юм.

	3373 \$/унц	+1.8	+1.1	+28.5	+40.0
Алт	Алтны үнэ өндөр түвшинд тогтвортой хэвээр байна. Энэ оны 9 болон 12 саруудад ХНБ бодлогын хүүгээ бууруулах магадлал нэмэгдэж байгаа нь алтыг сонирхох хөрөнгө оруулагчдыг нэмэгдүүлж байна. Нөгөө талаас төв банкнуудын алт худалдан авалт удааширч, БНХАУ, Энэтхэг улсуудад алтан үнэт эдлэлийн эрэлт буурч байгаа талаар Дэлхийн алтны зөвлөлийн тайланд тусжээ.				
	Түүнчлэн, тарифаас шалтгаалж инфляцын дарамт нэмэгдэж байгаа тул Citigroup-н зүгээс алтны үнэ ойрын 3 сарын дотор 3600 ам.доллар/унц болох төсөөлөл гаргаад байна.	68.7 \$/бар	-1.8	+0.7	-7.9
	Газрын тос (Брент)	Газрын тосны үнэ хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөгөөр хэлбэлзэж байна. ОПЕК+ бүлгээнийн зүгээс нийлүүлэлтээ нэмсэн хэвээр байна. Тэдний хувьд энэ оны 4-р сараас хойш сар бүр нийлүүлэлтээ нэмэгдүүлээд байгаа юм. Сүүлд 8-р сарын 3-нд болсон хурлаар 9-р сарын нийлүүлэлтээ дахин өдөрт 548 мянган баррелиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.	95.9 \$/тн	-3.9	+8.3
	Төмрийн хүдэр	Нөгөө талаас Дональд Трамп ОХУ-ыг Украинаад хийж буй дайнаа зогсоохыг удаа дараа тулган шаардав. <ul style="list-style-type: none"> 7-р сарын 14-нд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путинд хандаж 50 хоногийн хугацаанд Украинд өрнүүлж буй дайныг зогсоохыг уриалав. Хэрэв энэ хугацаанд багтаж үр дүнд хүрэхгүй бол ОХУ-аас газрын тос, байгалийн хий худалдан авч буй улс орнуудад хориг арга хэмжээ авах, тариф нэмэгдүүлэх талаараа мэдэгдсэн юм. 7-р сарын 28-нд хийсэн мэдэгдэлдээ хэлэлцээр хийх хугацааг наашлуулж, 10-12 хоногт багтааж дайныг дуусгахыг шаардлаа. Хэрэв дээрх хугацаанд дайн дуусахгүй бол хориг арга хэмжээ авах улсуудын дунд БНХАУ, Энэтхэг улсууд ч багтаж буй юм. 	+0.4	+0.3	
		БНХАУ-д байгаль орчны шаардлагыг хангаагүй эсвэл аюулгүй ажиллагааны стандартад хүрээгүй уурхайнуудын үйл ажиллагааг зогсоосноос үүдэн энэ оны 6-р сард БНХАУ-ын төмрийн хүдрийн олборлолт жилийн өмнөх үеэс 9.2 хувиар буурч, агуулах дахь нөөц багасав. Энэ нь БНХАУ-ын төмрийн хүдрийн импорт нэмэгдэх үндсэн шалтгаан болж, улмаар хурдтай буураад байсан төмрийн хүдрийн үнэ 7-р сарын турш өссөн байна. Гэвч БНХАУ-ын гангийн экспорт буурч байгаа, үл хөдлөхийн салбарын хямрал үргэлжилж байгаа, ойрын хугацаанд төмрийн хүдрийн нийлүүлэлтийн илүүдэл бий болох магадлалтай байгаа зэргээс шалтгаалж 8-р сарын эхээр үнэ эргэн буурч эхлээд байна. Цаашид ч үнэ үргэлжлэн буурах хүлээлттэй.			

	161 \$/тн	-4.2	+22.3	-3.4	-26.8
Коксжих нүүрс³					

Байгаль орчин, аюулгүй ажиллагаатай холбоотойгоор уурхайн үйл ажиллагааг зогсоох явдал нүүрсний салбарт ч мөн ажиглагдаж БНХАУ-ын нүүрсний дотоодын олборлолт буурав. Их бороо орсноос үүдэн зарим уурхайн үйл ажиллагаа доголдсон явдал ч гарсан байна. Харин энэ үед коксжих нүүрсний эрэлт тогтвортой байсан нь нүүрсний үнэ 7-р сард огцом өсөх (сарын 20+ хувиар) шалтгаан боллоо. SXCoal-н мэдээнээс үзэхэд сүүлийн өдрүүдэд хэд хэдэн уурхайн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж эхэлснээр коксжих нүүрсний үнэ эргэн буурч эхлэв.

БНХАУ-ын коксжих нүүрсний эрэлт энэ оны эхний 6 сард 297 сая тн байсан нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар өндөр дүн юм. Түүнчлэн, олон улсын эрчим хүчний агентлаг 2026 оныг дуустал нүүрсний эрэлт тогтвортой байх төсөөлөл гаргаснаа танилцуулав.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт:

Bloomberg Terminal

EU and US announce deal: a breakdown of the trade agreement - Al Jazeera

US, China hold new talks, tariff truce easing path - Reuters

Trump says US will set 15% tariff on South Korean imports under new deal - Reuters

US-China trade update - Politico

Trump says he thinks US will have "very fair" trade deal with China - Reuters

China economy and trade talks - AP News

Chinese trade diversion to US would cut Eurozone inflation, ECB blog says - Reuters

Chinese exports to US decrease by \$48.8 billion in trade war - Business Insider

Trump 2.0 tariff tracker - Trade Compliance Resource Hub

Full list of tariffs by country and rate - The Guardian

Who's included in Trump's latest adjusted tariffs - Al Jazeera

How are US-China trade talks going after new tariffs? - Al Jazeera

Copper price dynamics and US tariffs - Discovery Alert

Gold price extends gain as Fed rate cut looks likely - Mining.com

Brazil tariff order - CNN

OPEC brings back oil output amid uncertainty - Reuters

Trump's Russia-Ukraine deadline - TIME

European Commission Q&A on trade - European Commission

Japan-US trade agreement - CNN

BBC News trade article - BBC

Trump says US will set 15% tariff on South Korean imports under new deal (update) - Reuters

Korea, US prepare summit with trade details unresolved - Reuters

South Korea's trade deal with the US - CSIS

Malaysia agrees to boost LNG purchases from US - Reuters

China iron ore imports hold up as storm clouds gather - Reuters

³ Гашуунсухайт боомтын коксжих нүүрсний үнэ /БНХАУ-ын талын бүртгэл/

“ТӨСВИЙН ЗАРДЛЫН МӨЧЛӨГ, ТҮҮНИЙ ҮР АШИГ”

СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ХУРААНГУЙ



О.ЦОЛМОН

Монголбанкны Судалгаа, статистикийн
газрын эдийн засагч

Түүхий эдийн үнийн савлагаанаас ихээхэн хамааралтай, богино бизнесийн мөчлөгтэй манай улсын хувьд төсвийн бодлогоор дамжуулан хэлбэлзлийг бууруулж, мөчлөгийг уртасгах шаардлага тулгардаг. Энэхүү судалгаагаар Монгол

Улсын төсвийн бодлого эдийн засгийн мөчлөг сөрж, хэлбэлзлийг бууруулах чиглэлд хэр үр ашигтай ажиллаж байгааг тодорхойлж, бусад улстай харьцуулав.

ТОДОРХОЙЛОЛТ

- Мөчлөг сөрсөн төсвийн бодлого (countercyclical fiscal policy) гэдэг нь эдийн засгийн нөхцөл сайн (муу) үед ЗГ зардлаа бууруулах (өсгөх)-ыг хэлнэ. Энэ нь бизнесийн мөчлөгийг тогтворжуулах нөлөөтэй байдаг.
- Мөчлөг дагасан төсвийн бодлого (procyclical fiscal policy) гэдэг нь эдийн засгийн нөхцөл сайн (муу) үед ЗГ-ын зардлаа өсгөх (бууруулах)-ийг хэлнэ. Энэ нь бизнесийн мөчлөгийг улам өдөөх нөлөөтэй байдаг.
- Мөчлөгт бус төсвийн бодлого (acyclical fiscal policy) гэдэг нь ЗГ-ын зардал нь бизнесийн мөчлөгөөс үл хамаардаг буюу системчилсэн байдлаар өөрчлөгдхөхүй байхыг хэлнэ. Энэ бодлого нь бизнесийн мөчлөгийг тогтворжуулах эсвэл дэвэргэх аль ч талын нөлөөгүй байна

Аргачлал


Төсвийн мөчлөг дагалтыг тодорхойлохдоо Монголын эдийн засгийн мөчлөг болон төсвийн мөчлөгийг тус тус тодорхойлж, улмаар тэдгээрийн хамаарлыг тодорхойлсон юм. Эдийн засгийн мөчлөг (эдийн засгийн сайн, муу үе)-ийг тодорхойлохдоо Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний тоон мэдээллийг ашиглан эдийн засагчдын хамгийн түгээмэл ашигладаг аргачлал болох HP (Hodrick and Prescott) шүүлтүүрээр ялгасан бол төсвийн мөчлөг (төсөв тэлсэн, танасан үе)-ийг тодорхойлохдоо Kaminsky, Reinhart болон Výgh (2005) нарын санал болгосны дагуу Засгийн газрын зардлын тоон мэдээлэлд

үндэслэн мөн НР шүүлтүүрээр ялгасан. Шинжилгээнд Монголын болоод дэлхийн бусад улсын 1980 оноос 2022 он хүртэлх хугацааны жилийн давтамжтай тоон өгөгдлийг ашигласан болно.

Үр дүн

Манай улсын эдийн засгийн мөчлөг болон төсвийн мөчлөгийг дээрх аргачлалын дагуу тооцоолон, үр дүнг Зураг1-т үзүүлэв. Зургаас хараад 2000 оноос өмнө төсвийн мөчлөг нь эдийн засгийн мөчлөгийг дагаж байгаа нь илэрхий харагдаж байгаа бол 2000 оноос хойш уг хамаарал илэрхий харагдахгүй байна.

Зураг 1. Бизнесийн мөчлөг болон төсвийн зардлын мөчлөг




Тайлбар: НР шүүлтүүрээр тооцсон эдийн засгийн болон төсвийн мөчлөг. Эдийн засгийн мөчлөгийн 0-ээс их (бага) бол эдийн засгийн халалт (уналт)-тай үеийг, төсвийн мөчлөг 0-ээс их (бага) бол төсөв тэлсэн (агшсан)-г илрэхийлнэ. Мөн хүчтэй эдийн засгийн уналтын үеүдийг сүүдрээр тэмдэглэн, тайлбарыг байршуулав.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Төсвийн мөчлөгийн эдийн засгийн мөчлөг дагалтын зэргийг тодорхойлохын тулд хоорондын хамаарлын коэффициентыг тооцов (Хүснэгт 1). Манай улсын төсвийн зардал нь мөчлөг дагасан (1980-2023 хоорондын бизнесийн мөчлөг болон төсвийн зардлын мөчлөгийн хамаарал 0.626) шинжтэй байна. Тэр дундаа 2000 оноос өмнөх үеүдэд төсвийн мөчлөг дагасан байдал хамгийн өндөр, корреляцийн коэффициент 0.86 байжээ. 2000-2023 оны хооронд төсвийн бодлогын бизнесийн мөчлөгөөс хамаарах хамаарал 0.261 болж буурч, мөчлөгт бус төсвийн бодлого болсон байна¹.

Зураг 2. Монгол Улсын төсвийн бизнесийн мөчлөг дагалт, хугацааны турш



Цаг хугацааны туршид төсвийн мөчлөг дагалт хэрхэн өөрчлөгдсөнийг харуулах үүднээс хамаарлыг 16 жилийн цонхтойгоор гулсуулах (rolling) байдлаар хийж Зураг 2-д үзүүлэв. Төсвийн мөчлөг бизнесийн мөчлөгийг 2004 он хүртэл маш өндөр дагаж байсан бол 2005 оноос эхлэн мөчлөг дагалт харьцангуй буурсан дүр зурагтай байна.

Хүснэгт 1. Монгол Улсын төсвийн бизнесийн мөчлөг дагалт


Хугацаа	Хамаарлын коэффициент
1980-2022	0.626
1980-2000	0.856
2000-2023	0.261

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Бусад улсуудтай харьцуулалт харьцуулалт

ОУВС-ийн Засгийн газрын статистикаас тоон мэдээлэл нь олдох боломжтой 195 улсын төсвийн мөчлөг дагалтыг дээрх аргачлалынхаа дагуу тооцоолон, МУТАЙ харьцуулан Зураг 3-т үзүүлэв.

¹ Хамаарлын коэффициент эерэг боловч бага буюу суп хамааралтай байна.

Зураг 3. Улсуудын төсвийн мөчлөг дагалтын түвшин (1980-2022)

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Дийлэнх эдийн засгийн онолд төсвийн зардал нь мөчлөг сөрсөн байхыг сургадаг ч бодит байдалд ихэнх улсын төсөв мөчлөг дагасан байдаг байна. Тухайлбал, 195 улсаас 131 улсын төсвийн зардал нь эдийн засгийн өсөлтийг даган нэмэгддэг бөгөөд бүх улсын мөчлөгийн хамаарлын дундаж утга 0.16. Мөн улсуудыг эдийн засгийн хөгжлөөр нь ангилж харвал хөгжингүй орнуудад мөчлөг сөрсөн төсвийн зардал (хамаарал -0.12) зонхилж байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд мөчлөг дагасан төсвийн зардал (хамаарал 0.24) зонхилж байна.

Монгол Улсын хувьд 1980-2000 оны хоорондох төсвийн мөчлөг дагалтыг эдгэр улсуудтай харьцуулбал маш өндөр байна (Зураг 3). Харин манай улсын 2000-2022 оны мөчлөг дагалтын түвшин буурч, хамаарал 0.11 болсон нь бусад улсуудтай харьцуулахад ч мэдэгдэхүйц сайжирсан харагдаж байна (Зураг 3).


Төсвийн мөчлөгийн бусад тайлбар

Сүүлийн жилүүдэд мөчлөгөөс хамааралгүй болсон гэх үр дүн нь үнэхээр манай төсвийн бодлогын сахилга бат сайжирснаас шалтгаалсан уу эсвэл өөр хүчин зүйлс нөлөөлсөн үү гэдэгт хариулт өгөхийн тулд төсвийн мөчлөгийг сонгууль болон ОУВС-ийн хөтөлбөрийн үеүдтэй зэрэгцүүлэн тайлбарлахыг оролдлоо.

Зургаас хараад манай төсвийн бодлого нь эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамаарал зөвхөн улс төрийн нөлөөнд хэт хамааралтай байна. Тухайлбал, сонгуулийн үеүдэд зардлаа хэт тэлдэг, харин эсрэгээрээ ОУВС-ийн хөтөлбөрт орох үед төсвөө танадаг гэсэн зүй тогтолтой байна. Зүй нь эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан хэлбэлзлийг бууруулахад орших ёстой (Зураг 4).

Зураг 4. Төсвийн зардлын мөчлөг

(Эдийн засгийн мөчлөг, сонгууль болон IMF хөтөлбөрийн жилүүд)



Эх сурвалж: Судлаачийн дүрслэл

Дүгнэлт

Монгол Улсын төсвийн бодлогын мөчлөг дагалтыг судлахад төсвийн бодлого нь 1980 оноос 2023 он хүртэлх нийт хугацааг авч үзвэл мөчлөг дагасан гэж гарлаа. Тэр дундаа 1980-2000 онд төсвийн мөчлөг дагалт маш өндөр байсан бол 2000 оноос хойш энэхүү мөчлөг дагалт буурч, мөчлөгөөс хамааралгүй байх хандлагатай болжээ. Энэ нь сайшаалтай хэдий ч төсвийн мөчлөг нь сонгууль болоод ОУВС-ийн хөтөлбөрөөс ихээхэн хамааралтай байна. Тухайлбал, сонгуулийн жилүүд болох 2008, 2012, 2016 болон 2020 онуудад төсвийн зардлыг хамгийн ихээр тэлсэн байгаа бол эсрэгээрээ ОУВС-ийн хөтөлбөрт орсон 2001-2005, 2009-2010, 2017-2019 онуудад төсвийн зардлыг хамгийн ихээр танасан байна.

Бусад улсуудын төсвийн мөчлөг дагалтыг тооцоолон харахад ихэнх улсуудын төсөв мөчлөг дагасан буюу төсвийн зардал нь эдийн засгийн өсөлтийг даган өсөж, буурдаг байна. Харин хөгжингүй орнуудад мөчлөг серсөн төсвийн зардал зонхилж байгаа бол хөгжиж буй орнуудын хувьд мөчлөг дагасан төсвийн зардал зонхилж байна. Монгол Улсын хувьд 1980-2022 оны хоорондох төсвийн мөчлөг дагалтыг эдгээр улсуутдтай харьцуулахад маш өндөр буюу мөчлөг дагалтаараа эхний 13-т эрэмбэлэгдсэн бол 2000 оноос хойших хугацаанд төсвийн мөчлөг дагалт эдгээр улсуудын алтан дундаж түвшинд хүрчээ.

Ашигласан эх сурвалж:

- Auerbach, A. J., & Gorodnichenko, Y. (2012). Measuring the Output Responses to Fiscal Policy. *American Economic Journal: Economic Policy*, 1-27.
- Braun, M. (2001). Why Is Fiscal Policy Procydical in Developing Countries? *CIPPEC*.
- Gavin, M., & Perott, R. (1997). Fiscal Policy in Latin America. *NBER Macroeconomics*, 11-72.
- IMF. (2024 оны 11 30). Government Finance Statistics.
- Kaminsky, G. L., Reinhart, C. M., & Végh, C. A. (2005). *When It Rains, It Pours: Procydical Capital Flows and Macroeconomic Policies*. MIT Press. <http://www.nber.org/chapters/c6668>-ээс Гаргасан
- Klein, L. R., & Su, V. (1980). Recent Economic Fluctuations and Stabilization Policies: An Optimal Control Approach. *Quantitative Economics and Development*, 225-254.
- Lane, P. R. (2003). Business Cycles and Macroeconomic Policy in Emerging Market Economies. *International Finance*, 89-108.
- McManus, R., & Ozkan, F. G. (2015). On the Consequences of Pro-Cyclical Fiscal Policy. *Fiscal Studies*, 29-50.
- Talvi, E., & Vegh, C. (2000). Tax Base Variability and Procydical Fiscal Policy. *NBER working series*.
- Woo, J. (2009). Why Do More Polarized Countries Run More Procydical Fiscal Policy? . *The Review of Economics and Statistics*, 850-870.
- Д.Ган-Очир, & Л.Даваажаргал. (2017). Монголын эдийн засгийн том хэмжээний BVAR загвар: Гадаад шокийн нөлөө. *Мөнгө, Санхүү, Баялаг*, 49-71.
- Л.Даваажаргал, & Б.Хүслэн. (2018). Бизнесийн мөчлөгийг тодорхойлох нь. *Мөнгө, санхүү, баялаг*, 55-68.
- Л.Даваажаргал, & О.Цолмон. (2022). Потенциал үйлдвэрлэлийг тооцох нь. *Судалгааны товхимол*, 123-135.
- Л.Даваажаргал, & Э.Элбэгжаргал. (2022). Түүхий эдийн зах зээл дээрх өөрчлөлтийн макро эдийн засгийн нөлөө. *Судалгааны товхимол*, 6-21.
- С.Баттулга, & нар. (2024). Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийдийн хэрэгжилтийн гол асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх арга зам. *Нээлттэй нийгэм форум*.

